

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2008 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн зохицуулах хороо холбогдох хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, Хорооны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тодорхой үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ 2008 оныг “Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, энэ ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний тусгай төлөвлөгөө гарган мөрдөж ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д “Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна” гэсэн заалтын дагуу өөрийн харьяалах салбарын үйл ажиллагааг зохицуулах цаг үеийн тулгамдсан 320 асуудлыг 19 удаагийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 294 тогтоол, 7 тэмдэглэл гаргаж, олон нийтэд тухай бүр мэдээлэн, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Гаргасан нийт тогтоолын 45 нь салбарын эрх зүйн зохицуулалттай, 178 нь зах зээлийн зохицуулалттай, 37 нь иргэд, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай, 34 нь бусад асуудлуудтай тус тус холбоотой байв. Хорооны зохицуулалтын хүрээнд хамрагдах санхүүгийн салбаруудын өмнө тулгамдсан маш олон асуудлууд байгааг 1 удаагийн хуралдаанаар дунджаар 17 асуудал хэлэлцэж байсан байдал илтгэн харуулж байгаа юм.

Хороо гадаад, дотоодын байгууллага, иргэдээс нийт 4321 албан бичиг, факс хүлээн авч, 3038 албан бичгийг гадагш явуулж, иргэдээс ирүүлсэн 451 өргөдөл, гомдлыг хянан шалгаж барагдуулснаас үзэхэд бичиг хэргийн эргэлтийн хувьд ажлын 1 хоногт 32 албан бичиг оногдсон байна.

Хорооны Ажлын алба нь Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар, Тамгын газар, Эрх зүйн хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс гэсэн 7 дотоод бүтцийн нэгжтэйгээр ажиллав.

Санхүүгийн бүх салбарт санхүүгийн тайлагналыг үнэн зөв гарган, хуулийн хугацаанд нь олон нийтэд хүргэх ажлыг хэвшил болгохгүй, бүртгэл хөтлөлтөд НББОУС-ыг бүрэн нэвтрүүлэхгүй, аудит, үнэлгээний ажлын чанарыг эрс сайжруулахгүй бол хөрөнгө оруулагч, хадгаламж эзэмшигчид ихэд хохирч болзошгүй байгаад дүгнэлт хийн Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газрыг шинээр байгуулсныг дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагууд сайшаан дэмжиж байна. Энэ газар нь зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудит, үнэлгээний дүгнэлтэд чанарын шинжилгээ хийж, бодит мэдээллээр хангах замаар Хорооноос бодит байдалд нийцсэн, шударга шийдвэр гаргахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх юм.

Нийт 98 ажилтны 45.9% нь эрэгтэй, 54.1% нь эмэгтэй бөгөөд боловсролын түвшингээр нь ангилбал, эдийн засгийн ухааны доктор 2, дэд профессор 1, эдийн засгийн ухааны магистр 24, Бакалавр 57, тусгай дунд боловсролтой 3, бүрэн дунд боловсролтой 2 хүн байна.

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу СЗХ-ны Ерөнхий менежерээс Төсвийн ерөнхийлөн захирагчтай, нэгжийн менежерүүд Ерөнхий менежертэй, ажилтнууд нэгжийн менежерүүдтэй шат шатандаа үр дүнгийн гэрээ байгуулан, хагас жил тутам дүгнэн ажиллаж, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг Сангийн яам, Төрийн албаны зөвлөлд хуулийн хугацаанд нь хүргүүлж байв.

Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүдийн жил, сарын ажлын төлөвлөгөөг Хорооны үйл ажиллагааны дунд хугацааны хэтийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, гүйцэтгэлд нь Тамгын газар, дотоод хяналтын албаны зүгээс тогтмол хяналт тавьж эрчимжүүлэн, биелэлтийг нь ханган ажиллалаа.

Хорооны нийт ажилтнууд, иргэд, харилцагч нарыг эрх зүйн зөвлөгөөгөөр хангах ажлыг сайжруулж, түргэн шуурхай болгох зорилгоор СЗХ байгуулагдсанаас хойшх хугацаанд Хорооны хуралдаанаас гаргасан тогтоол, шийдвэрүүдийг эрх зүйн лавлагааны сан болгон нэгтгэж, албан ажлын хэрэгцээнд ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.

Байгууллагын архивын материалыг Архивын тухай хуулийн дагуу цэгцлэх ажлын хүрээнд Үнэт цаасны хорооны 1975-2005 оны баримт бичгүүдийг 151 хадгаламжийн нэгж болгон эмхлэж, байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах баримтын түүвэр жагсаалт зэргийг гарган Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 2008 оны 4-р сарын 25-ны өдрийн 8-р хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хүлээлгэн өгсний зэрэгцээ СЗХ-ны 2006-2008 оны баримт бичгүүдийг нийт 717 хадгаламжийн нэгж болгон, байнга хадгалах баримтын нэгдсэн бүртгэл гаргаад ажилтнуудад ашиглуулах болсон.

Хорооны бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг сурталчлах, гаргасан шийдвэр, баталсан журам, зааврыг олон нийтэд шуурхай хүргэх нэг хэлбэр болох байгууллагын цахим хуудсыг сайжруулж, ADB-ийн техникийн туслалцааны ажлын хүрээнд “Dell Power Eadge-2900” хоёр ширхэг серверийг шинээр суурилуулсан. Тэдгээр дээрээ өөрийн дотоод сүлжээ, цахим хуудас (www.frc.mn) болон и-мейл серверээ байршуулснаар Хорооны гадаад, дотоод сүлжээний хэвийн ажиллагаа бүрэн хангагдах болсон. Түүнчлэн Вэб сайтынхаа бүтэц, дизайныг шинэчлэн, ашиглахад хялбар болгож, мэдээлэл оруулалт, санал, асуулгын хариуг тогтмол өгч, монгол, англи хувилбарыг зэрэг ажиллуулах болсноор Хорооны сайтад хандагсдын тоо эрс нэмэгдэн, давхардсан байдлаар 58.000-д хүрсэн юм.

СЗХ-ны дэргэдэх Санхүүгийн боловсролын нэгдсэн төв"-ийн барилга барих асуудлыг УИХ, Засгийн газраас дэмжин санхүүжүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2.5 тэрбум төгрөг суутган баталсан билээ. Өнгөрөгч оны хувьд уг барилгын ажлын зураг, төсвийн ажлыг хийж, суурийг тавих зориулалтаар 500 сая төгрөг хуваарилсан боловч холбогдох газруудын шийдвэр гаргалтын явц удаашралтай байснаас 56.8 сая төгрөгөөр зураг, төсөв, инженер-геологийн судалгаа зэргийг хийлгэсэн болно.

Хороо ажилтнуудынхаа мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэргийг ахиулах гол хэлбэр бол сургалт, семинар юм гэж тодорхойлоод, ялангуяа зохион байгуулагч талын санхүүжилтээр зохиогдож буй арга хэмжээнүүдэд өргөнөөр хамруулах бодлого барин ажиллаж байгаа болно. Тайлант онд үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн зохицуулалт, хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагатай холбоотой сэдвээр Япон, Хятад, Герман, Тайланд, АНУ, Франц, Унгар, Люксембург, Солонгос, Гонг-Конг, Индонези, Тайван

зэрэг орнуудад болсон сургалт, семинаруудад давхардсан тоогоор 39 ажилтан, дотоодод зохиогдсон хурал, уулзалт, семинаруудад давхардсан тоогоор 72 ажилтан хамрагдсан байна.

Түүнчлэн гадаад орнуудын их, дээд сургуулиудад 4, дотоодын их, дээд сургуулиудад 5, Удирдлагын академид 5, докторантурт 2 хүн тус тус суралцаж байгаа нь Хороо өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх эрмэлзэлтэй байдаг ажилтнуудынхаа санал, санаачлагыг бүрэн дэмжин ажилладгийн илрэл юм.

Ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийт ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу байгалийн үзэсгэлэнт газруудаар аялуулан, Төрийн албаны хууль, холбогдох бусад эрхийн акт, журам, зааврын дагуу тэдгээрт эмчилгээний нөхөн олговор, тэтгэмж, буцалтгүй тусламжийг бүрэн олголоо.

Хороо банкнаас бусад санхүүгийн зах зээлийг богино хугацаанд олон улсын жишигт хүргэн хөгжүүлж бэхжүүлэх, зохицуулалтыг нь боловсронгуй болгох, Хорооны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагууд болон олон улсын хандивлагч байгууллагуудтай тогтоосон харилцаагаа бататган гүнзгийрүүлэхэд анхаарч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд:

- Олон улсын валютын сан /IMF/, Дэлхийн банк /WB/, Европын сэргээн босголтын банк /EBRD/, Азийн Хөгжлийн Банк /ADB/ зэрэг олон улсын санхүүгийн байгууллагын техникийн туслалцаагаар даатгал, үнэт цаас, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн орчин, хяналт шалгалтын ажлыг сайжруулах төслүүд хэрэгжүүлж, төрөлжсөн сургалт семинаруудыг зохион байгууллаа.
- Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага (IOSCO)-ын “Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг”-т нэгдэхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор ADB-гийн санхүүжилтээр ирж ажилласан зөвлөх мэргэжилтний гаргасан зөвлөмжийн дагуу шаардлагатай баримт бичгийг боловсруулан холбогдох газар нь илгээгээд байна.
- БНХАУ-ын Үнэт цаасны хороотой хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэдээлэл солилцох, хамтран ажиллах хоёр талт харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсны дээр ОХУ, БНСУ, Гонг-Конг, Казакстан, Польш зэрэг орны ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичиг зурахаар тохиролцон, Хорооноос шалтгаалах бэлтгэл ажлыг хангаад байна.
- БНСУ-ын хөгжлийн агентлаг /КОИКА/-тай мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, програм хангамжийг сайжруулах, и-архив байгуулах, зөвлөх үйлчилгээ авах, сургалт зохион байгуулах талаар; Дэлхийн банктай СЗХ-ны чадавхийг дээшлүүлэх төслийн хүрээнд санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтыг сайжруулах талаар тус тус санал солилцож, шаардагдах төсөл, хөтөлбөрийн баримт бичгүүдийг хүргүүллээ.
- Люксембургийн Вант Улсын Ерөнхий сайд Монгол Улсад хийсэн айлчлалынхаа үеэр Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын СЗХ-ны “Санхүүгийн боловсролын нэгдсэн төв”-ийг тохижуулах, санхүүгийн салбарын чадавхийг дээшлүүлэхэд зориулж 2 сая еврогийн буцалтгүй туслалцаа үзүүлэхээр тохирч санамж бичиг үзэглэсэн.
- JICE, GTZ, USAID, ADB зэрэг хөгжлийн агентлагууд болон хандивлагч байгууллагуудтай санхүүгийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, зөвлөх үйлчилгээ авах, гадаад орнуудын мэргэжлийн байгууллагуудаас зохион явуулж буй сургалт,

хурал, цуглаанд оролцох чиглэлээр хамтран ажиллахын зэрэгцээ үнэт цаас, даатгалын олон улсын байгууллагуудаас зохион байгуулагдсан жилийн болон бүсийн уулзалт, хуралдаануудад гишүүний хувьд идэвхтэй оролцож байна.

- Япон, Турк, Сингапур, Энэтхэг улсын Элчин сайдын яамдтай тогтоосон найрсаг харилцаагаа гүнзгийрүүлж, хамтын ажиллагааныхаа чиглэл, хэлбэрийг тогтоогоод байна.

Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээртэй хамтран ажиллах харилцаа холбоогоо бэхжүүлэх зорилгоор зарим гэрээ, хэлцлүүдийг байгууллаа. Тухайлбал,

- Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой Канадын Хоршоологчдын холбооноос санхүүжүүлэх “ХЗХ-дын чадавхийг дээшлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх талаар “Харилцан ойлголцлын санамж бичиг”;
- Хас банктэй ХЗХ-дод франчайзын үйлчилгээ үзүүлэх талаар “Харилцан ойлголцлын санамж бичиг”;
- Монголбанктэй зээлийн мэдээллийн сангийн ашиглалтын талаар “Хамтын ажиллагааны гэрээ”;
- Үндэсний статистикийн хороотой санхүүгийн зах зээлийн статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох талаар “Хамтран ажиллах санамж бичиг”;
- Үндэсний татварын ерөнхий газартай мэдээллийн санг хамтран ашиглах талаар “Хуулийн этгээдийн мэдээллийн санг ашиглах гэрээ” зэргийг дурдаж болно.

ХОЁР.САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

1. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАР

Тайлант онд хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах, үнэт цаас гаргах үйл ажиллагааг идэвхжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилт тавин ажиллалаа.

А. Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар

СЗХ байгуулагдсан цагаас хойш манай хамт олон салбарынхаа эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэх асуудлыг чухалчилж, салбарын хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлт, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, зарим шинэ хуулийн төслийг тус тус боловсруулан холбогдох газруудад хүргүүлж байсан хэдий ч өнөөг хүртэл хараахан батлагдаж чадаагүй байсаар байгаа юм.

Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хүчтэй мэдрэгдэх болж, дэлхийн олон улс гүрнийг хамарсан санхүүгийн хямрал, түүний шалтгаан, үр дагавар нь санхүүгийн салбарын зохицуулалтад тавигдах шинэ шинэ шаардлагуудыг нээн өгсөөр байна. Тэдгээр шаардлагуудад нийцүүлэн Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Компанийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай зэрэг хуулиудын төсөл, үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн

найруулгын төслийг холбогдох Ажлын хэсэгтэй нь хамтран шинээр боловсруулж, заримыг нь Засгийн газарт хүргүүлсэн.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд дорвитой нөлөө үзүүлэх нэг арга зам бол хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх явдал бөгөөд энэхүү хөгжлийг хангахад төр, засгийн цэгцтэй бодлого шаардлагатай гэдэгтэй эдийн засагчид санал нэгтэй байдаг. Тийм ч учраас СЗХ “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг үзэл баримтлал, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хамт өмнөх жилүүдэд боловсруулсан билээ. Уг баримт бичгийг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцээд дэмжин зөвшөөрснийг, Хорооны гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийн дагуу дахин нарийвчлан хянаж, зохих өөрчлөлтүүдийг оруулан, УИХ-д өргөн барихад бэлэн болгосон.

Хороо хөрөнгийн зах зээлийг зохицуулах, мэргэжлийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг НББОУС-д нийцүүлэх зорилгоор хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай", "Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай", "Брокер, дилерийн үйл ажиллагааны тухай", "Тендер санал гаргах, дүгнэх тухай", "Үнэт цаас гаргагчид зайнаас хяналт тавих тухай", "Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай", "Үнэт цаас гаргагч болон зах зээлийн мэргэжлийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлан, түүний тодруулга, хураангуйг хэвлэн нийтлэх тухай" зэрэг 16 журам, заавар, маягтыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүллээ.

Өнгөрөгч оны эхний хагаст үнэт цаасны зах зээл дээрээс урт хугацаатай хөрөнгө оруулалтын эх үүсвэр босгож, үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа өргөжүүлэх эрмэлзэл манай бизнес эрхлэгчдийн дунд өргөжих хандлагатай байсан нь өмнөх онд улс орны санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч, аж ахуйн нэгж, иргэдийн гар дээр бэлэн мөнгөний хуримтлал тодорхой хэмжээгээр бий болсонтой холбоотой байсан. Үүнийг нь Хорооны зүгээс бодлогын хүрээнд дэмжиж, улмаар энэ зах зээлийн эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор “Гермес центр”, “Хөх ган”, “Монад”, “Ремикон”, “Монфреш жүүс”, “Анод банк” зэрэг 6 компанид анхдагч зах зээл дээр хувьцаагаа нийтэд санал болгон худалдах, “Зоос банк”, “БиДиСЕК” зэрэг компанид нэмж хувьцаа гарган арилжаалах зөвшөөрөл олгож, эдгээр компанийн нийт 85.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 500 сая ширхэг хувьцааг бүртгэсэн байна. Мөн шинээр байгуулагдсан “Монголын төмөр зам” төрийн өмчит ХК-ийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 226.000 ширхэг хувьцаа, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-аас олон улсын үнэт цаасны зах зээл дээр гаргах 150 сая хүртэлх ам.долларын бонд, 25 сая хүртэлх ам.долларын хоёрдогч өглөгийг бүртгэсэн.

Зах зээлийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр мэргэжлийн байгууллагын хувьд оролцон ашиг хүртэх сонирхол ихсэх хандлагатай болж, тусгай зөвшөөрөл авахтай холбоотой хүсэлт олноор ирэх болсныг Хороо холбогдох журам, зааврын дагуу хянан шийдвэрлэж байлаа. Тайлант онд үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байсан 6 компанийн брокер дилерийн, 2 компанийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчилж, ЭфСиЭкс, Нортонсек, Финанс линк групп, Лайфтайм инвестмент, Лондоназиа капитал, ӨүСиБи зэрэг 7 компанид брокер, дилер, андеррайтерийн, 4 компанид брокер дилерийн, 1 компанид брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олголоо.

Үнэт цаасны зах зээл дээр онцгой байр суурь, үүрэгтэй мэргэжлийн хамгийн гол байгууллага болох Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТХ/-ийн үйл ажиллагааг Хорооны шийдвэрээр болон Төлөөлөн удирдах зөвлөлд нь байдаг өөрийн төлөөлөгчөөр дамжуулан бодлого, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Санхүүгийн зах зээлд итгэх иргэдийг итгэлийг бататгах нэг чухал хэрэгсэл бол тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалах явдал байдаг. Тайлант онд иргэд, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор гарсан Хорооны 37 тогтоолоос хүлээн зөвшөөрөөгүйн улмаас захиргааны хэргийн шүүхэд хандсан 6 гомдлыг хянан шийдвэрлэх 20 удаагийн шүүх хуралдаанд оролцож, Хорооноос гаргасан шийдвэр зөв байсныг нотолж чадсан юм.

Өмч хувьчлалын явцад төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, ямар нэг шалгуургүйгээр Хөрөнгийн биржид бүртгэж байсан. Тэдгээрийн дийлэнх нь олон жил дараалан алдагдалтай ажиллаж, өмч хөрөнгө нь үрэгдэж, үйл ажиллагаа нь зогссон төдийгүй компанийн засаглалын шаардлагыг хэрэгжүүлдэггүйгээс хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэггүй, хувьцаа нь бирж дээр идэвхтэй арилжаалагдаггүй хэдий ч бүртгэлээс хасагдаагүй байсаар байна.

2006-2007 онуудад хувьцаат компаниудын үйл ажиллагаанд хийсэн үзлэгийн дүнгээр 200 шахам ХК ажиллахаа болиод 3-аас дээш жил болсон, 70 гаран компанийн хөрөнгө үрэгдэж, хариуцах эзэнгүй болсноор цаашид ажиллах боломжгүй болсон нь илэрсэн юм.

Энэ нь тухайн компанийн хувьцааг эзэмшиж буй мянга мянган жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг үл тоомсорлодог, нийт хувьцааны дийлэнх хэсгийг эзэмшиж буй цөөн тооны хүмүүсийн хяналтгүй, дур зоргоороо аашилж буй үйлдэл бөгөөд нөгөөтэйгүүр, эзэмшиж буй хувьцааныхаа үнэ цэнийг ойлгоогүй, сул орж ирсэн цэнхэр, ягаан тасалбарын мөн чанарыг мэдрээгүй, аливаад хэнэггүй ханддаг монгол сэтгэхүйн үр дагавар байсан бололтой. Цаашилбал, олон нийтийн эрх ашгийн байгууллага болох хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын механизм ямар нэгэн хуулиар зохицуулагдаагүй орхигдсон, ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын хүчин төгөлдөр байх эсэхийг хуралд ирэгсдийн эзэмшиж буй хувьцааны нийт хувьцаанд харьцах хувь хэмжээгээр тогтоохоор Компанийн хуулинд заасан зэрэг хуулийн цоорхой, амьдралд нийцээгүй заалтууд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг бүдүүлгээр зөрчих, хохироох боломжийг бүрдүүлсэн байлаа.

Хороо шалгалтын дүнгээр цаашид ажиллах боломжгүй болсон гэж дүгнэгдсэн ХК-дын асуудлыг дампууруулах, хэлбэрийг нь өөрчлөх, татан буулгах зэрэг аль тохирох арга замаар шийдвэрлэн Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасч цэвэрлэх нь зах зээлийнхээ цаашдын хөгжилд нааштайгаар нөлөөлнө гэж үзээд эхний ээлжинд 165 ХК-ийн үнэт цаасны арилжааг 2008 оны 3 дугаар сарын сүүлчээс эхлэн зогсоосон. 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Хороо “Арилжааг зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 77 тоот тогтоол гаргаж, эдгээр компанийн удирдлагад хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хуралдуулж, цаашид үйл ажиллагаагаа сэргээх эсэх, компаниа татан буулгах эсэх талаар гаргасан шийдвэрээ Хороонд ирүүлэх хугацаатай үүрэг өгсөн. Хувьцаат компани ямар ч шийдвэр гаргалаа гэсэн СЗХ эн тэргүүнд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг урьтал болгон, ямар нэгэн хэмжээгээр хохироохгүй байх бүх талын арга хэмжээг авах болно. Тайлант онд үнэт цаасны арилжааг нь зогсоосон 165 компанийн жагсаалтад багтсан 12 компани хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг хуралдуулж, компанийн хэлбэрээ өөрчлөн ХХК

болохоор шийдвэрлээд, Хороонд хүсэлтээ гаргасныг хянан үзээд зөвшөөрсний дагуу 9.944 хүний 975532 ширхэг хувьцааг бүртгэлээс хасч, хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох 337.5 сая төгрөгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансдад нь байршуулсан.

2008 онд хөрөнгийн зах зээлтэй холбоотой асуудлаар нийт 316 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд барагдуулахад онцгой анхаарч ажиллалаа. Гэвч 1996-2004 онуудад ихэвчлэн тохиолдож байсан иргэдийн хувьцааг өөрсдөд нь мэдэгдэлгүйгээр зарж борлуулсан үйлдэл шийдвэрлэхэд ихэд ярвигтай, хугацаа шаардсан, хуучин шинэ эзэмшигчдийн хооронд ширүүн маргаан татсан, гол төлөв шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлэгддэг асуудал байдаг учраас Хорооны бүрэн эрхийн хэмжээнд тэр бүр хуулийн заасан хугацаанд шийдвэрлэх боломжгүй байсан юм. Хороонд хандан ирүүлсэн дээрх 316 өргөдөл, гомдлын 80.5 хувь буюу 255 нь иргэдийн эзэмшиж байсан хувьцааг зөвшөөрөлгүй зарсан асуудлаар гаргасан гомдол байсан бөгөөд үүний 70 орчим хувийг л гэхэд тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан брокер, дилерийн Ажнай, Мөнхөд гэсэн 2 компанитай байв. Энэ компаниудын буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон гэж өргөдөл гаргаад байгаа иргэдийн тоо 300 орчим, хохирлын хэмжээ нь өнөөгийн зах зээлийн үнээр тооцоход бараг 1.5 тэрбум төгрөг болж байсан тул хэргийг шалгуулахаар Улсын мөрдөн байцаах газар, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэст шилжүүлсэн болно.

Өнөөдөр үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа брокер, дилерийн компаниудтай холбоотойгоор иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэх асуудал дагуу нийт 160 гаруй сая төгрөгийн хохирлыг барагдуулан шийдвэрлэлээ.

Хороо 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг сурталчлан таниулах, хувьцаат компаниудаар мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХК-дын удирдлагуудад 1 өдрийн сургалт зохион байгуулсанд 70 гаран хүн хамрагдсан. Үүний үр дүнд өнгөрсөн жил Хөрөнгийн биржид бүртгэлтэй 376 ХК-иас 120 нь хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг хийж, 138 нь санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлсэн төдийгүй 2007 онд 28 компани 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан бол тайлант онд 25 компани 17.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

Хувьцаа эзэмшигчдээс Хороонд ирүүлж буй өргөдөл, гомдлын үнэн бодит эсэхийг нягтлан шалгах нэг чухал хэрэгсэл бол харилцагч Брокер, дилерийн компанийн бичиг баримт байдаг. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн эхэн үед мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаад татан буугдсан зарим БДК-ийн баримт материал үрэгдэж алга болсноос иргэдийн гомдлыг барагдуулахад төвөгтэй байдал үүсдэг учир Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байсан БДК-ийн харилцагчдын бичиг баримтыг аймгийн архивт шилжүүлж, хадгалуулах болов.

Б. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар

Санхүүгийн зах зээлд итгэх иргэдийн итгэлийг бататгах нэг гол хүчин зүйл нь иргэд, тухайн зах зээлийн мэргэжлийн оролцогч нарын санхүүгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, зах зээлийн үйл явц, олон нийтийн ашиг сонирхол бүхий компаниудын талаарх үнэн зөв мэдээлэл, санхүүгийн тайланг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох ажил байдаг.

Энэ чиглэлээр СЗХ-оос зохион байгуулсан “Санхүүгийн зах зээлийг сурталчлах өдөрлөг”-т үнэт цаасны салбарын 20 гаруй мэргэжлийн байгууллага, Хөрөнгийн бирж, ҮЦТТХТ-ийн 200 орчим ажилтнууд идэвхтэйгээр оролцон, байгууллагаа сурталчлах, иргэдийн дансны үлдэгдлийг шалгаж өгөх, баталгаажуулах, шинээр харилцах данс нээлгэх хүсэлтэй иргэдэд үнэ төлбөргүйгээр данс нээх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, хүссэн мэдээллээр нь хангах зэргээр нийт 150 шахам хүнд үйлчлэв. Мөн түүнчлэн хөрөнгийн зах зээлийн талаар анхны ойлголт авахад зориулагдсан гарын авлага, материалуудыг тараахын зэрэгцээ “Хөрөнгө оруулалтын тухай үндсэн ойлголт”, “Та брокероо хэрхэн сонгох вэ” зэрэг сэдвээр лекц уншсан нь олны таашаалыг хүртэж байлаа.

Үнэт цаасны салбарын эрх зүйн болон зах зээлийн зохицуулалтын хүрээнд хийгдэж буй ажил, мэргэжлийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэл, салбарын холбогдолтой мэдээ, мэдээллийг тухай бүр Хорооны цахим хуудас дээр байршуулж, шинэчлэх ажлыг тогтмолжуулан ажиллав.

2008 онд Хороо, Үнэт цаасны газрын удирдлагуудаас “С1 телевиз”-ийн “Бизнесийн цаг” хөтөлбөрт 4 удаа, “Ийгл телевиз”-ийн ярилцлагад 2 удаа оролцож, хөрөнгийн зах зээлийн цаг үеийн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл хийж, үзэгчдийн сонирхсон асуултад хариулсны дээр “Өнөөдөр”, “Зууны мэдээ” зэрэг сонинд 5 удаа ярилцлага өгч, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар сурталчлав.

Үнэт цаасны зах зээл дээр ажиллагсдад зориулсан семинар, уулзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар зохион байгуулж, нийт 376 хүн хамруулсан байна.

Тайлант онд үнэт цаасны зах зээл дээр ажиллахыг хүсэгчдэд анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөрөнгийн биржийн сургалтын төвөөр дамжуулан, мэргэжлийн эрх олгох сургалтыг СЗХ-ны сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтын агуулга, чанарт онцгой анхаарч, шинэчлэн сайжруулсан бөгөөд 2 хоног байсан үргэлжлэх хугацааг нь 14 хоног болгон сунгаж суралцагчдад илүү гүнзгий, илүү өргөн мэдлэг олгох нөхцлийг бүрдүүлсэн юм. Мэргэжлийн эрх олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 184 хүнийг хамруулж, 149 хүнд эрхийн үнэмлэх олгосон байна.

В. Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар

Олон улсын практикаас харахад, хяналт шалгалт, зохицуулалтын байгууллагууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах асуудалд онцгой ач холбогдол өгөн ажиллаж, энэ үүргээ биелүүлж буй арга механизмууд, хуримтлуулсан туршлага, олсон амжилтын талаар гадаад, дотоодын ажил үйлс нэгтэнгүүдтэйгээ байнга хуваалцаж байна.

Хороо хандивлагчид, зохион байгуулагч талын зардлаар хийгдэж буй энэ төрлийн сургалт, семинаруудад ажилтнуудаа аль болох өргөн оролцуулан, үр өгөөжтэйгөө харуулсан туршлага, санаачлагуудыг судлан өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэхэд анхаарч байна.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдалд хийх хяналт шалгалтын ажлыг стандартчилан тогтмолжуулах нь санхүүгийн гэмт хэрэг, зөрчил гарах явдлаас урьдчилан сэргийлэх шалгарсан арга хэлбэр юм. Хэдийгээр Брокер, дилер, андеррайтерын компаниудын үйл ажиллагааг удирдамж гарган дагуу хатуу

шалгаагүй ч тусгай зөвшөөрөл сунгах ажлын хүрээнд ажилтай нь нарийн танилцаж, зөрчил илэрсэн нэр бүхий 6 /Дархан, Масдак, Аргай бест, Бумбат Алтай, Эрдэнэст, Ники/ компанитай холбоотой асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцэн, үйл ажиллагаа нь зогсоон, тусгай зөвшөөрлийг нь түтгэлзүүлэх арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулж байсан болно.

Төрийн хяналт суларч, эмх замбараагүй байдал газар авснаас хувьцаа эзэмшигчдийн дансан дахь хувьцааг зөвшөөрөлгүйгээр зарж борлуулан, арилжаалдаг байсан зохисгүй үзэгдэл хумигдаж, мэргэжлийн оролцогчид маань ёс зүй, нэр төрийн үнэт зүйлсээ эрхэмлэх хандлагатай болж байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд хувьцааг зөвшөөрөлгүй зарсан тохиолдол шинээр гараагүй бөгөөд иргэдээс зөвхөн өмнөх онуудад хийгдсэн хууль бус ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлууд ирж байна.

Тайлант онд Улаанбаатар хот, Орхон, Дархан –Уул аймагт байршдаг хувьцаат болон шинээр нийтэд санал болгон хувьцаагаа гаргасан 50 орчим компанийн үйл ажиллагаанд шалгалт хийн, удирдлагатай нь уулзалт зохион байгуулж, санал солилцлоо.

Компанийн тухай хуульд олон нийтийн ашиг сонирхлын байгууллага болох хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналтын механизм шаардлагын хэмжээнд тусгагдаагүй, хариуцлага тооцох хэлбэр, хэмжээ нь тодорхойгүйгээс үүдэлтэй дараах хууль бус үйлдэл, зөрчлүүд нийтлэг гардгийг шалгалтын дүн харууллаа. Үүнд:

- үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг, Компанийн тухай хуулийн 60.3-д заасан хувь нийлүүлэгчдийн хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулах үүргээ биелүүлдэггүй, үүнээс улбаалаад компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болсон;
- хуулийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулаагүй, үнэт цаасаа бүртгэлээс хасуулаагүй хэрнээ ХХК болж хэлбэрээ өөрчлөн Улсын бүртгэлийн албанаас гэрчилгээ авсан, хувь нийлүүлэгчиддээ оногдох хөрөнгийг өгөлгүйгээр хувьцааны хяналтын багцыг эзэмшигчид компанийн өмч хөрөнгийг хувааж аван үрэгдүүлсэн;
- хуулийн дагуу санхүүгийн тайлангаа эрх бүхий байгууллагуудад хүргүүлдэггүй, санхүүгийн тайлангийн хураангуйг өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр нийтлүүлж хувьцаа эзэмшигчдэдээ санхүүгийн байдлынхаа талаар мэдээлдэггүй;
- хувьцааны хяналтын багцыг эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааг худалдаж авах тендер санал гаргаагүй, компанидаа хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэнийг бусад хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдээгүй зэргээс саналын эрхгүй болсон;
- хувь нийлүүлэгчдийн хооронд өмч хөрөнгийн маргаантай асуудал үүсч шүүх, хуулийн байгууллагад хандаад байгаа, хандах шаардлагатай болсон нөхцөл байдал үүссэн зэргийг дурдаж болно.

Шалгалтын удирдамжийн дагуу шалгалтад хамрагдсан компаниудын эзэмшилд байгаа хөрөнгийн бүртгэлийг Өмч хувьчлалын комисс, Төрийн өмчийн хороо, Нийслэлийн өмч хувьчлалын газрын уг компаниудын хувьчлагдах үеийн шийдвэрт тусгагдсан үндсэн хөрөнгийн бүртгэлтэй тулган үзэхэд зарим хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтнууд, хувьцааны хяналтын багцыг эзэмшигчид компанийнхаа үл хөдлөх хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэн авч, жижиг хувьцаа эзэмшигчдийг ноцтойгоор хохироосон үйлдлүүд илэрч байв. Эдгээр хууль бус үйлдэлд холбогдох этгээдийг хуулийн байгууллагаар

шалгуулах, зарим компанийг татан буулгах асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хороо хувьцаат компани, мэргэжлийн байгууллагуудад хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд 4.7 сая төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулсан байна.

Г.Зах зээлийн өнөөгийн байдал

2008 оны байдлаар хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй 376 хувьцаат компани, 46 брокер, дилер, андеррайтерийн компани, үнэт цаасны арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо, хадгаламжийн 1 байгууллага, нийт 48 мэргэжлийн оролцогч үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд системийн хэмжээнд 6.5 тэрбум төгрөгийн орлого олж, 6.4 тэрбум төгрөгийн зардал гарган 32.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Нийт орлогын 87 хувийг нэр бүхий 9 компани гүйцэтгэсэн бөгөөд 2008 оны дунд үеэс үнэт цаасны арилжааны идэвх суларч, борлуулалтын хэмжээ багассантай холбоотойгоор БДК-иуд арилжааны шимтгэлийнхээ хувь хэмжээг багасгасан явдал үндсэн орлогын хэмжээ буурахад нөлөөлсөн бол шинээр байгуулагдсан мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны зардал системийн нийт зардлын хэмжээг өсөхөд нөлөөлжээ.

БАЛАНС	Системийн дүн
ХӨРӨНГӨ	
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,291,188,955.94
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,361,083,760.11
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,652,272,716.05
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,417,244,233.73
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,339,805,526.55
Өр төлбөрийн нийт дүн	6,757,049,760.28
Эзэмшигчдийн өмч	
Өмч: а) төрийн	1,867,708,800.00
б) хувийн	7,802,581,476.49
Халаасны хувьцаа	2,796,285,000.00
Хувьцаат капиталын дүн	12,466,575,276.49
Хуримтлагдсан ашиг	1,349,498,958.84
Тайлангийн үеийн	32,483,893.23
Өмнөх үеийн	1,317,015,066.61
Эзэмшигчдийн өмчийн дүн	14,895,222,955.36
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,652,272,716.05

Нийт системийн хувьцаат капиталын 76 хувь хувийн компаниудад оногдож байгаа бол “Монголын хөрөнгийн бирж”, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” гэсэн төрийн өмчит 2 компани үлдсэн 24 хувийг буюу 1.8 тэрбум төгрөгийн хувьцааг эзэмшиж байна.

1. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, ДНБ-д эзлэх хувь



Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 28 хувиар багасч, түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ өмнөх оныхоос 53.5 хувиар буурч 8.4 хувьтай тэнцэх болжээ. Энэ нь нэг талаар ХК-дын хувьцаа цөөн хүний мэдэлд хэт төвлөрснөөс улбаалан хэлбэрээ өөрчилж ХХК болох хандлага сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, эдгээр компаниудын үнэт цаас Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдаж байгаа, нөгөө талаар санхүүгийн хямралт байдлын нөлөөллөөр энэ салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ эрс багассанаас хувьцааны ханш унаж байгаатай холбоотой юм.

2. Хувьцаа



Үндэсний томоохонд тооцогддог хаалттай компаниуд олон нийтэд үнэт цаасаа санал болгон худалдаж ХК-ийн хэлбэрээр ажиллан, үйл ажиллагаагаа өргөсгөн тэлэх сонирхолтой болж байна. Энэ нь тухайн зах зээлийг сонгодог утгаар нь хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлж, хөрөнгө оруулагчдад сонголт хийх өргөн боломж олгох зөв үзэгдэл юм.

Гэсэн хэдий ч хувьцааны арилжааны дүн өмнөх оныхоос 1.7 тэрбум төгрөгөөр буюу 3%-иар буурсан нь өнгөрөгч оны сүүлийн хагасаас хөрөнгийн зах зээл дэх гадаадын шууд хөрөнгө оруулалт багасч, улс орны хэмжээнд мөнгөний хомсдол бий болсноос үнэт цаасны худалдах хандлага давамгайлах болсон, үнэт цаас худалдан авах эрэлт багассан нь үүнд нөлөөлсөн болох нь судалгаагаар харагдаж байна. Улмаар нийлүүлэлтийн илүүдэл нь хувьцааны үнэ ханшийг унагаж буй үндсэн хүчин зүйл болж байгаа ба цаашид ч үргэлжлэн унах нь гэсэн “айдас” хөрөнгө оруулагчдыг хувьцаагаа худалдахад нөлөөлж байна.

Дэлхий нийтийн санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын зүгээс үнэт цаасны зах зээлд оруулсан хөрөнгөө буцаан татах үйл явц явагдаж байна. Судалгаанаас үзэхэд, хувьцаагаа зарж буй хувьцаа эзэмшигчид гаргаж авсан мөнгөөрөө дахин хөрөнгө оруулалт хийлгүй, өдөр тутмын хэрэгцээндээ зориулан зарцуулж байгаа юм.


3.Топ-20 индекс



1999 оноос эхлэн хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр сонгосон 20 үнэт цаасаар багц бүрдүүлэн “ТОП-20 индекс”-ийг тооцож үнэт цаасны зах зээлийн хөдөлгөөнийг харуулдаг болсон. Энэ индексийн багцыг жилд хоёр удаа шинэчилдэг бөгөөд түүний өсөлт, бууралтаас зах зээлийн хөгжлийн ерөнхий хандлага өндөр мэдрэмжтэйгээр шалтгаалдаг тул тогтмол тооцон харж, зохицуулалтын арга хэмжээг уялдуулан авч хэрэгжүүлдэг юм.

ТОП-20 индексийн 2007 оны хаалт 10,256.13 нэгж байсан бол 2008 оны хаалт 5,583.2 нэгж болж бараг 50 орчим хувиар буурсан байна. Энэ нь зах зээлийн үнэлгээний зонхилох хувийг эзэлж, хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг үнэт цаасны арилжаа багасч, ханш нь буурч, зах зээл өөрөө уналтын шинжтэй болж, төрөөс бодлогын хувьд дэмжих шаардлагатай байгааг харуулж байна.

4. Бонд



Засгийн газрын “40 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан 60.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэл болох дунджаар 295 хоногийн хугацаатай, 10.0 хувийн дундаж хүүтэй 20.0 тэрбум төгрөгийн бондыг 2008 онд худалдахаар санал болгосон хэдий ч 1.5 тэрбум төгрөгийн бонд борлогдсон байна. Үүнээс гадна “Монинжбар” компанийн 24 сарын хугацаатай, 10.8 хувийн хүүтэй 0.5 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийгдсэн.

Инфляцын түвшин 24-32 хувь, банкуудын хадгаламжийн жилийн дундаж хүү 18 хувьтай байгаа өнөөгийн нөхцөлд дээрх 2 бондын санал болгож буй өгөөжийн түвшин хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж чадаагүй байна.

Д. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг үндсэн үзүүлэлт нь зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдхүүнд харьцуулсан харьцаа байдаг. Энэ үзүүлэлт өндөр хөгжилтэй Герман, Япон, Өмнөд Солонгос, Их Британи, АНУ зэрэг улсуудын хувьд 52.6 – 160.2%, манай оронтой нэгэн адил 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжсэн ОХУ, Хятад, Казахстан, Киргизстан зэрэг орнуудын хувьд 41.6-89.7 хувь байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжил бол эдийн засгийн өндөр хөгжлийн нэг гол хүчин зүйл юм гэдгийг илтгэн харуулж байна.

Тэгвэл манай орны хувьд энэхүү харьцаа 2005 онд 2.2 хувь байсан бол 2007 он гэхэд 15.7 хувь болтлоо өссөн хэдий ч 2008 онд 8.4 хувь болж буурснаас дүгнэхэд Монголд хөрөнгийн зах зээл хөгжиж чадаагүйгээс улс орныхоо эдийн засагт мэдрэгдэхүйц хувь нэмэр оруулж чадахгүй байна.

Дэлхий дахинд үүсээд буй санхүү, эдийн засгийн хямралын улмаас улс орнуудын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд ихээхэн унаж байгаа бөгөөд уг хямрал хэдий хугацаагаар үргэлжлэх нь тодорхойгүй, дэлхийн эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэдэг хөгжингүй орнуудын санхүү, эдийн засгийн байдалд нааштай хандлага ажиглагдахгүй байгаа зэргээс шалтгаалан цаашид ч үргэлжлэн буурах магадлалтай юм.

2008 онд дэлхийн хөрөнгийн биржүүдийн үнийн индекс дунджаар 46.6%-иар, Ази номхон далайн бүсийн биржүүдийнх дунджаар 47.9%-иар, Нью-Йоркийн Dow Jones индекс 36%-иар, Лондонгийн FTSE 100 индекс 32%-иар, Токиогийн NIKKEI 225 индекс 45%-иар тус тус буурсан бол Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс 45.5%-иар буурчээ.

2007 онд гадаадын хөрөнгө оруулагчид Монголын үнэт цаасны зах зээл дээр 25 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн бол 2008 онд 52%-иар багасч 10.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн ба 2007 онд нийт арилжааны үнийн дүнгийн 60%-ийг гадаадын хөрөнгө оруулагчдын хийсэн арилжааны дүн эзэлж байсан бол 2008 онд энэ үзүүлэлт 30% болон буурсан байна. Гадныхан 2008 оны сүүлийн хагасаас эхлэн манай улсын үнэт цаасны зах зээлд хийж байсан хөрөнгө оруулалтаа их хэмжээгээр буцаан татах болсон нь дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын нөлөөлөл үйлчилсэнтэй холбоотой байж болох талтай.

Олон улсын валютын сангийн 2008 оны 10 дугаар сард хийсэн судалгаагаар дэлхийн дахины ДНБ-ий өсөлт 2007 онд 5.2 хувь байсан бол 2008 онд 3.4 хувьтай болж буурсан бөгөөд 2009 онд 0.5 хувь хүртэл огцом унана гэж тооцоолоод, 2010 оны эцэс гэхэд 3 орчим хувьтай байх магадлалтай гэж үзсэн байна. Хэрэв энэ тооцоолол үнэн бол ойрын 2 жилд манай улсын хөрөнгийн зах зээлд хийгдэх дотоод, гадаадын хөрөнгө оруулалт хязгаарлагдмал, зах зээлийн үнэлгээ, арилжааны үнийн дүн буурах хандлагатай байх магадлал өндөр байна.

Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд

Хөрөнгийн зах зээлийн талаар 2009 онд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг дараах үндсэн 6 чиглэлээр тодорхойлж байна:

1.Хөрөнгийн зах зээлийн талаар төрөөс баримтлах дунд хугацааны бодлогыг тодорхойлж Хорооноос баталсан “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онуудад хөгжүүлэх хөтөлбөр”-т тусгагдсан зарим арга хэмжээнүүдийг нөөц бололцоогоо дайчлан хэрэгжүүлж эхлэхийн хамт уг хөтөлбөрийг Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулснаар төр, олон нийтийн дэмжлэгийг авч, бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, төр, засгийн холбогдох байгууллагуудын оролцоо, үүрэг хариуцлагыг тодорхой болгоно.

2.Нэгэнт боловсруулж бэлэн болгосон Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай зэрэг хуулиудын төсөл, оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг эрх бүхий этгээдээр дамжуулан Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлгийн явцад идэвхтэй хамтран ажиллан батлуулснаар хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

3.Олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад орнуудын ижил төстэй байгууллага, дипломат албадтай тогтоосон хамтын ажиллагаагаа идэвхжүүлэн, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллана. Энэ ажлын хүрээнд Олон улсын үнэт цаасны хороодын байгууллага /IOSCO/-ийн олон талт Харилцан ойлголцлын санамж бичигт нэгдэн орох асуудлыг шийдвэрлэж, бүс нутгийн улс орнуудын зохицуулах байгууллагуудын санхүүгийн зах зээлийн зохицуулалтын талаар хуримтлуулсан дэвшилтэт арга хэрэгслүүдийг судлан хэрэгжүүлэх талаар бүх талын чармайлт гарган ажиллана.

4. Хөрөнгийн биржийн ХК-дын үнэт цаасны бүртгэлд тавих шаардлагыг өндөрсгөж, чанар муутай үнэт цаасыг бүртгэлээс хасах замаар цэвэрлэдэг болох нь Үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь хөгжүүлэхэд чухал түлхэц болно. Хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах нэг арга зам болсон бүртгэл цэвэрлэх ажлыг Хөрөнгийн бирж болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран хийнэ.

5. Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг нэвтрүүлэн мөрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Энэ чиглэлээр ХК-дад зөвлөмж, шаардлага хүргүүлэх, ХК-дын удирдах бүрэлдэхүүнд зориулсан сургалтуудыг “Компанийн сайн засаглалын зарчмууд” сэдвийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

6. “Санхүүгийн боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд батлагдах тусгай төлөвлөгөөнд Үнэт цаасны салбартай холбогдон тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг бүрэн биелүүлнэ.

2. ДААТГАЛЫН САЛБАР

Тайлант онд даатгалын салбарыг хөгжүүлж төлөвшүүлэх, даатгалын зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор даатгалын хуулиудад орсон даатгалын багц дүрмийг боловсруулж дуусгах, даатгалын байгууллагуудад зайнаас тавих хяналтыг хүчтэй болгох, урт хугацааны даатгалын тогтолцоо нэвтрүүлэх боломж, арга замыг судлах, даатгалын зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, даатгалын салбарын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох, даатгуулагчдын мэдлэгийг дээшлүүлж, эрх ашгийг нь хамгаалах зэрэг асуудалд гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

А. Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар

Монгол улсын даатгалын салбарын харилцааг зохицуулж буй “Даатгалын тухай”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуулиуд батлагдаад удаагүй, харьцангуй сайн боловсрогдсон гэж тооцогддог тул энэ салбарын эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэхэд эдгээр хуулиудад заагдсан багц дүрмийг зах зээлийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулах явдал нэн чухал байлаа.

Өмнөх жилүүдэд Даатгалын тухай хуульд заагдсан “Даатгалын багц дүрэм” болох 21 журам, зааврыг боловсруулан батлуулж, мөрдүүлэн ажиллаж байсан бол 2008 онд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн багц дүрэм” болох 20 гаруй журам, заавар, аргачлалыг боловсруулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Даатгалын салбарт урт хугацааны буюу амьдралын даатгалын тогтолцооны эхлэл тавагдаж, энэ чиглэлээр ажиллах компани бий болсонтой холбогдуулах энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг даатгалын ерөнхий 2 хуульд нийцүүлэн боловсруулж батлууллаа. Ингэснээр даатгалын салбарын мэргэжлийн оролцогчийн болон урт хугацааны даатгагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт сайжирч, төрийн зүгээс даатгалын зах зээлд тавих хяналтыг боловсронгуй болгох нөхцөл бүрдсэн юм.

Өнгөрсөн 3 жилийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдгээр дүрэм, журам, заавар, стандарт, нөхцөл шаардлагыг хууль тогтоомжийн хамт нэгтгэн “Даатгалын

зохицуулалтын эрх зүйн актын эмхтгэл” нэртэйгээр хэвлүүлэн түгээсэн нь даатгагчдын мэргэжлийн гарын авлага төдийгүй даатгуулагчдын чухал зөвлөгч болсон ном болов.

Хөгжингүй орнуудын даатгалын салбарын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох мэргэжлийн хариуцлагын даатгалын тогтолцоог бодлогын хувьд хөхиүлэн дэмжиж, илүүтэйгээр хөгжүүлсний үр дүнд энэ салбарын эдийн засгийн бүтцэд эзлэх хувийн жин өндөр, өсөлтөд нь мэдрэгдэхүйц нөлөө үзүүлдэг байна. Тухайлбал, Европын Холбооны улсууд болон АНУ-д мэргэжлийн хариуцлагын заавал даатгалын төрлүүдийн эзлэх хувийн жин дэлхийн бусад орнуудтай харьцуулахад нилээд өндөр байдаг. Жишээлэхэд, Франц улс мэргэжлийн хариуцлагын заавал даатгалын хамгийн олон төрлүүдийг батлан мөрдөж байгаа бөгөөд энэ нь 100 орчим заавал даатгалын тухай бие даасан тус тусдаа хуулиудаар зохицуулагдаж байна.

Үүний жишгээр Монгол Улсад энэ төрлийн даатгалын хэлбэрийг нэвтрүүлэх эхлэлийг тавих, гуравдагч этгээдийн буруугаас иргэдэд учирч болох хохирлын нөлөөллийг багасгах явдал чухлаар тавигдаж байгааг харгалзан “Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай хууль”-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн барьсан. Энэ хууль батлагдсанаар даатгалын салбарын хөгжилд эргэлтийн чанартай, дэвшилтэт алхам хийгдэх болно гэж ойлгож байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос Олон улсын даатгалын хяналтын холбоо (IAIS)-той тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, даатгалын холбогдолтой мэдээлэл солилцон үйл ажиллагаанд нь оролцохын хамт бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын даатгалын зохицуулалтын ижил төрлийн байгууллагуудтай холбоо тогтоож, цаашид хамтран ажиллахад ач холбогдол өгч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд ОХУ-ын Сангийн яамны Холбооны даатгалын хяналтын алба болон Автотээврийн даатгагчдын холбоотой шинээр харилцаа тогтоож, улмаар Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо, ОХУ-ын Сангийн яамны хооронд санхүүгийн салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулах талаар санал солилцож, тохиролцоонд хүрсэн.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)-ны техник туслалцааны шугамаар “Даатгалын салбарын зохицуулалтыг сайжруулах” TCS ID: 20299 төслийг Английн зөвлөх компанитай хамтран хэрэгжүүлж, Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, мөрдөгдөж байгаа даатгалын журам, заавар, аргачлалуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн сайжруулах талаар судалгаа хийж, эхний дүгнэлтийг гаргалаа.

Олон улсын валютын сангийн техник туслалцааны төслийн хүрээнд даатгалын олон улсын экспертийг урьж ажиллуулан, даатгалын зах зээлийг богино болон дунд хугацаанд хөгжүүлэх чиг бодлогыг тодорхойлох чиглэлээр хамтран ажиллаж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой тохиролцоонд хүрээд байна.

2008 онд даатгалын 16 компанид давхардсан тоогоор 43 даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгон, 2 даатгагчийн 6 хэлбэрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хасч хүчингүй болгож, 1128 хүнд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

Даатгалын салбарт урт хугацааны буюу амьдралын даатгалын эхлэлийг тавьж, эн төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Нэйшнл лайф даатгал” ХХК-д олгосон

нь манай орны хувьд шинэлэг үйл явдал болсон юм. Тус компанийхан үйл ажиллагааныхаа талаар өргөн хүрээтэй сурталчилгаа явуулж, амьдралын даатгалын шинэ шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж эхэлснээр нилээд олон даатгуулагчтай болж чаджээ.

Даатгалын зах зээл дээр даатгалын мэргэжлийн оролцогчдын хүрэлцээ дутмаг байгаад анхаарч, Хороонд хүсэлтээ ирүүлсэн “Эм эн ай” болон “Эм жи ай би” ХХК-иудад даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон. Харамсалтай нь, “Эм эн ай” ХХК зохих шаардлагын түвшинд ажиллаж чадаагүй тул тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн хэдий ч ажил нь сайжрахгүй байсан учир тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон.

Даатгалын тухай хуульд заасны дагуу даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрхийг 30 хүнд аудиторт, ердийн болон урт хугацааны даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 9 хүнд тус тус олгосон байна.

Даатгалын зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахад өндөр ач холбогдол өгч, хүч чармайлт тавьж ажилласан болно. 2007 онд эрх ашиг нь зөрчигдсөн даатгуулагчдаас 28 өргөдөл, гомдол Хороонд ирж байсан бол 2008 оноос даатгагчид ч Хороонд хандан санал хүсэлтээ ирүүлдэг болсон бөгөөд тайлангийн хугацаанд нийт 57 өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авч хянан, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн төдийгүй иргэд, хуулийн этгээдэд тус салбарын зохицуулалтын тухай асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан болно. Мөн түүнчлэн даатгалтай холбоотой асуудлаар иргэд, харилцагчдаас 502 албан бичиг ирүүлсэнд тухай бүр хариуг хүргүүлснээс гадна 226 албан бичиг холбогдох газруудад илгээжээ.

Автотээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгал нь сайн дурын даатгалд хамаардаг хэдий ч тээврийн хэрэгслийн жолооч нараас заавал даатгалын журмаар хураамж авч, иргэдийг бухимдуулдаг зөрчил өмнөх жилүүдэд удаа дараа гардаг байсан. Энэ хууль бус үйлдлийг таслан зогсоож, дахин гаргуулахгүй байх зорилгоор автотээврийн хэрэгслийн улсын үзлэг, тооллогын үеэр даатгалын компаниудаас автотээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагыг даатгалд хамруулах ажлыг иргэдийг хохироолгүйгээр, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа байдалд Замын цагдаагийн газартай хамтран хяналт тавьж ажилласан.

Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжин орсноос хойшх 20-иод жилийн хугацаанд даатгалын салбарын үйл ажиллагааг хувийн хэвшлийнхэн эрхлэн явуулах болж, зах зээлд шинэ төрлийн олон бүтээгдэхүүнийг нэвтрүүлж буй хэдий ч энэ салбарт иргэдийн сэтгэл ханамжид бүрэн нийцсэн ажил, үйлчилгээ үгүйлэгдсээр байгаа юм. Энэ нь нэг талдаа даатгалын салбар мэргэжлийн боловсон хүчнээр туйлын дутагдмал, үйл ажиллагаа нь харилцагч нарт тэр бүр ил тод байж чаддаггүй, нөгөө талаас даатгал нь санхүүгийн алдагдлын эрсдэлээс хамгаалах хэрэгсэл, тогтвортой амьжиргааны баталгаа мөн болохыг олон нийтэд ойлгуулах ажил бодлоготойгоор хийгдэхгүй байгаагийн илрэл билээ.

Хороо энэ байдалд дүгнэлт хийн, даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчний мэргэшил, чадавхийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарал хандуулж, олон удаагийн төрөлжсөн сургалтыг зохион байгууллаа. Тухайлбал:

- даатгалын төлөөлөгч нарт зориулсан сургалтыг 32 удаа;
- даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх аудиторуудад зориулсан сургалтыг 1 удаа;
- даатгалын хөрөнгийн удирдлага, актуарын тооцооллыг сайжруулах сэдэвт сургалтыг 2 удаа /Люксембургийн ЗГ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд Даатгагчдын холбоотой хамтарч/;
- малын индексжүүлсэн даатгалд малчдыг хамруулах асуудлаар хөдөө орон нутагт ажиллах даатгалын төлөөлөгчдийг бэлтгэх сургалтыг 3 удаа /“Малын индексжүүлсэн даатгалын төсөл”-ийн нэгжтэй хамтарч/ тус тус зохион байгуулсан болно.

Эдгээр сургалтуудад давхардсан тоогоор нийт 2 мянга шахам хүн хамрагдан бэлтгэгдсэн нь даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал түлхэц болсон гэж үзэж байна.

Иргэдэд даатгалын ач холбогдлыг ойлгуулж, тэднийг амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагын учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах ажлыг нэг гол хэлбэр бол даатгуулагчдыг даатгалын салбарын үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн мэдээ, мэдээлэл, ойлгоход хялбар үг хэллэгээр бичигдсэн танилцуулга, гарын авлагаар тогтмол хангах, даатгуулагчдад хүссэн үед нь түргэн шуурхай зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Хорооноос 2008 онд зохиосон “Санхүүгийн зах зээлийг сурталчлах өдөрлөг”-т зориулан даатгалын салбарыг зохицуулж буй бүх хууль тогтоомж, журам, зааврыг багтаасан “Даатгалын зохицуулалтын эрх зүйн актын эмхтгэл”-ийг АХБ-ны Санхүүгийн салбарыг шинэчлэх чадавхийг бэхжүүлэх төслийн нэгжтэй хамтран хэвлүүлж, түгээсэн нь даатгалын зах зээлд оролцогч байгууллага, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болсон.

Даатгалын салбарын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс даатгалын зах зээлийн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр Хорооноос авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд, баталж мөрдүүлж байгаа журам, зааврууд, түүнчлэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгчид, даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрх авсан аудиторууд, даатгалын санхүүгийн тайлан, нэгтгэлтэй холбоотой төрөл бүрийн мэдээллийг Хорооны вэб-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, шаардлагатай тохиолдолд албан бичгээр лавлагаа гарган өгч ажиллалаа.

Тайлант онд иргэд, даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Урт хугацааны даатгалын тухай”, “Даатгал гэж юу вэ”, “Даатгалын асуулт хариулт”, “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн анхааралд”, “Ердийн даатгалын хэлбэрийн тайлбар” зэрэг нийтлэлүүд гаргаж, даатгалын зах зээлд шинээр нэвтэрч байгаа бичил даатгал болон амьдралын даатгалын асуудлуудаар холбогдох хурал, зөвлөгөөн дээр 3 удаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн ба Монголын радиогоор 3 удаа ярилцлага өгсөн байна.

В.Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар

Даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд тавих хяналтыг Хорооноос даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл

ажиллагаанд төлөвлөгөөт болон сэдэвчилсэн шалгалт хийх, санхүүгийн байдал нь зайнаас хяналт тавих зэрэг хэлбэрүүдээр хэрэгжүүлж байна.

Тайлант онд “Бодь даатгал”, “Прайм женерал даатгал”, “Миг даатгал”, “Жонон даатгал”, “Ганзам даатгал”, “Аме” зэрэг даатгалын мэргэжлийн оролцогч компаниуд, Орхон, Дархан-Уул. Хэнтий аймгууд дахь даатгалын компаниудын салбарын үйл ажиллагааг газар дээр нь очиж шалгалаа.

Даатгалын байгууллагуудын үйл ажиллагаанд 2007 онд газар дээр нь хийсэн шалгалтаар Хорооноос даатгалын төлөөлөгчийн эрх аваагүй хүмүүсээр дамжуулан даатгуулагчтай даатгалын гэрээ хийж, эдгээр хүмүүст даатгагчаас шимтгэл урамшуулал төлсөн нийтлэг зөрчил илэрч байсан бол 2008 онд ийм хэрэг зөрчил бараг гараагүй нь өмнөх хяналт шалгалтын үр дүн, ололттой тал байсан гэж дүгнэж болох юм.

Харин тайлант онд хийсэн газар дээрх шалгалтаар даатгалын компаниуд хөрөнгө оруулалтын зорилгоор дүрмийн сан болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгөнөөс дур мэдэн зарцуулах, Хорооноос тавьж буй шаардлагыг санаатайгаар зөрчиж, тогтоосон лимитийг хэтрүүлэх, зориулалт бусаар ашиглах зэрэг зөрчил урьд урьдаас илүүтэйгээр гаргах болсон нь илэрсэн тул цаашид үүнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд хяналт шалгалтын ажлыг улам сайжруулах хэрэгтэй байна.

Санхүүгийн байгууллагад тавих зайны хяналт бол нэг талаар бодлого тодорхойлох үндэслэл, нөгөө талаар эрсдэлийн удирдлагын хэрэгсэл, цаашилбал статистик мэдээллийн эх үүсвэр болдог. Түүнийг хэрэгжүүлэх явцад тухайн байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийн, хөрөнгө, санхүү нь зохистой харьцааны хэмжээнд байгаа эсэхийг нягтлан шалгаж, анхаарал татаж буй үзүүлэлтүүдийг тодруулан залруулах сэдэвчилсэн үзлэг хийх хүрээг тодруулдаг.

Өнгөрсөн онд даатгалын компаниудын санхүүгийн тайланг улирал бүр хүлээн авч, нэгтгэн шинжилж, зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлэх явцад даатгагчид санхүүгийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байсан ба харин компаниудын хооронд харьцуулан үзэхэд ихээхэн зөрүүтэй байлаа. Энэ үзүүлэлт зарим компани дээр бодит байдалд нийцэж байгаа эсэхэд нь эргэлзээ төрөхүйц өндөр гарсан нь цаашид зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцоолох аргачлалыг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай байгааг харууллаа. Иймд Хорооноос даатгалын байгууллагуудын санхүүгийн улирлын тайлангийн үзүүлэлтүүдэд нэгдсэн дүн шилжилгээ хийж, компанийн санхүүгийн чадварыг илтгэх зохистой харьцаануудыг шинээр тогтоох судалгааны ажил явуулж, зарим аргачлалыг туршилтын журмаар нэвтрүүлж байна.

Тайлант хугацаанд шалгалтаар илэрсэн буруутай үйл ажиллагаа, зөрчил дутагдалтай холбогдуулан нийт 6 сая төгрөгийн торгуулийг даатгалын компаниудад хүлээлгэж, улсын төсөвт бүрэн төвлөрүүлсний зэрэгцээ алдаа дутагдлыг засч залруулах, таслан зогсоох үүрэг, даалгаврыг Улсын байцаагчийн албан шаардлагаар өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.


Г.Зах зээлийн өнөөгийн байдал

Тайлант онд даатгалын салбарт ердийн даатгалын хэлбэрээр 16, урт хугацааны буюу амьдралын даатгалын хэлбэрээр 1 компани үйл ажиллагаа явуулж, системийн хэмжээгээр

21.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, 4.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгон, 1.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Даатгалын компаниуд нөөцийн сангийн хэмжээгээ 3.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 21.4 тэрбум төгрөгт хүргэсэн бөгөөд 4.7 тэрбум төгрөгийн давхар даатгал хийлгэсэн байна.

2007 онд даатгалын салбарын хураамжийн орлогын 81.9 хувийг нэр бүхий 5 компани хуримтлуулж байсан бол 2008 онд энэ тоо 79.1 хувь болж буурсан нь даатгалын зах зээл дээрх өрсөлдөөн чангарч, жижиг, дунд хэмжээний компаниудын үйл ажиллагаа идэвхжиж байгаагийн илрэл юм.

1.Нийт хөрөнгө




Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос 12.3 хувиар буюу 3.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 31.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант онд даатгалын салбарт 1 тэрбум төгрөгийн дүрмийн сан бүхий амьдралын даатгалын компани шинээр байгуулагдсаныг тооцон үзвэл энэ үзүүлэлтийн өсөлт өмнөх оныхтой харьцуулахад саарсан байдалтай байна.

2.Хураамжийн орлого



Даатгалын хураамжийн орлого сүүлийн жилүүдэд дунджаар 1.9 орчим тэрбум төгрөгөөр тогтвортой өсч байгаад 2007 онд 43.2 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн билээ. Дэлхийн олон улсыг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал Монголд ч гэсэн нөлөөллөө үзүүлж байгаа хэдий ч 2008 онд энэ үзүүлэлт 4.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нэг талаас даатгалын зах зээлд шинэ төрлийн шинэ бүтээгдэхүүн олноор нийлүүлэгдэх болсон, нөгөө талаас иргэд маань ч даатгалын ач холбогдлыг илүүтэйгээр ойлгох болж, учирч болох эрсдэлээс хамгаалахын тулд илүүтэйгээр даатгуулах хандлагатай байгаатай холбоотой юм.


3.Хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь




Даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2007 онд 0.05 пунктээр буюу 5.2 тэрбум төгрөгөөр өсч байсан бол энэ онд 0.02 пунктээр буурахад санхүүгийн хямралт байдал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байгаа. Дэлхийн хөгжингүй орнуудын хувьд 10 орчим хувь байдаг энэ үзүүлэлт Монголд 0.5 хувь ч хүрэхгүй байгаа нь манай даатгалын зах зээлийн хүрээ цаашид тэлж хөгжих өргөн боломжтойг, иргэд, олон нийтийн даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар дорвитой ажил хийх ёстойг, энэ салбарт амьдралын болон төрөл бүрийн хариуцлагын заавал даатгалын хэлбэрүүдийг нэвтрүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна. Нэг хүнд ноогдох хураамжийн орлого 1500 төгрөгөөр өсч 8000 мянгад хүрсэн байна.

4.Нөхөн төлбөр

Даатгалын компаниудаас даатгуулагчдад төлсөн нөхөн төлбөр 2007 онд 21.6 хувиар өсч байсан бол тайлант онд 32.4 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний дийлэнх хэсгийг эд хөрөнгийн даатгалын болон хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн өсөлт эзэлж байна.



5.Хохирол нөхөлтийн түвшин



Даатгалын салбарын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн өөрчлөлтийн динамик хандлагаас харахад, даатгалын хураамжийн орлогын хэмжээ нь нөхөн төлбөрийн хэмжээнээс бараг 5 дахин өндөр байна. Энэ харьцаа, ялангуяа сүүлийн хоёр жилд, эрс ихсэх хандлагатай болсон нь даатгалын нэр хүндийг унагаж, иргэд, даатгуулагчдын итгэлийг бууруулж, даатгалын зах зээлийн хөгжилтөд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Даатгалын салбарын хохирол нөхөлтийн түвшинг Монголд нийт нөхөн төлбөрийг нийт хураамжийн орлогод харьцуулан тооцож хэвшсэн байсан бөгөөд энэ үзүүлэлт тайлант онд 20.9 хувьтай байлаа. Харин олон улсын практикийн дагуу нийт нөхөн төлбөрийг даатгалын орлогод тооцсон хураамжид харьцуулан /loss ratio - 100 төгрөгийн хураамж тутмын хэдэн төгрөгийг даатгуулагчдад нөхөн төлбөр болгон буцаан олгож байгааг харуулдаг/ тооцсоноор бол хохирол нөхөлтийн түвшин 30.6 хувьтай гарсан нь өмнөх оныхоос даруй 18 хувиар бага байна.

Д. Дэлхийн даатгалын зах зээлийн өнөөгийн байдал

Дэлхийн бүх улс орнуудад 98000 гаруй даатгалын компани ажилладаг бөгөөд тэдгээрийн 12.2 хувь буюу 12000 гаруй нь зөвхөн АНУ-ын компаниуд байдаг байна. 2008 онд дэлхийн хэмжээнд даатгалын хураамж 1985 оноос хойш анх удаагаа буурсанд олон улсыг хамарч байгаа санхүү, эдийн засгийн хямралын улмаас дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 3.4 хувь болж буурсан явдал нөлөөлжээ.

2008 оны эхний хагас хүртэлх санхүүгийн жилд дэлхийн даатгалын зах зээл дээр амьдралын даатгалын хураамжаар 1.6 триллион, амьдралын бус даатгалын хураамжаар 2.4 триллион, нийт дүнгээрээ даатгалын хураамжаар 4 триллион долларын орлого олсон нь 2007 оныхтой харьцуулахад 1% буурсан байна.

Даатгалын хураамжийн орлогын дүнгээрээ АНУ тэргүүлж, дэлхийн зах зээлийн 30.28 хувийг эзэлж байгаа бол Их Британи - 11.42 %, Япон - 10.46%, Франц - 6.62%, Герман - 5.49%, Итали - 3.50%, Канад - 2.47%, БНХАУ - 2.28%-ийг тус тус эзэлж байна.

Азийн орнуудын хувьд даатгалын хураамжийн орлогын өсөлт нь БНХАУ-д 27.5%, БНСУ-д 24.1%, Вьетнамд 29.5% байгаа бол манай улсын хувьд 27.2% өсчээ.

Даатгалын хураамжийн орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа нь тухайн орны даатгалын хөгжлийн түвшинг илэрхийлдэг бөгөөд энэ үзүүлэлтээр Лихтенштэйн /301.68%/, Люксембургийн вант улс /42.49% /, Их Британи /17.48%/ зэрэг орнууд хамгийн өндөр үзүүлэлттэйд тооцогддог. Монголын даатгалын хураамжийн орлого ДНБ-хээ 0.35% эзэлж буй нь 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн Казакстан /0.39%/, Вьетнам /0.42%/, ОХУ /0.57%/, Украин /0.85%/, Болгар /0.89%/ зэрэг орнуудынхтай харьцангуй ойр байгаа болно.

Дэлхийд даатгалын хураамжийн орлогоороо AXA group /162.8 тэрбум доллар/, Allianz group /140.6 тэрбум доллар/, Berkshire Hathaway /118.2 тэрбум доллар/, Assicurazioni Generali /113.8 тэрбум доллар/, AIG /110.1 тэрбум доллар/, Prudential /98.5 тэрбум доллар/ компаниуд тэргүүлсэн бол давхар даатгалын хураамжийн орлогоороо Munich Re /30.3 тэрбум доллар/, Swiss Re /27.7 тэрбум доллар/, Berkshire Hathaway Re /17.4 тэрбум доллар/, Hannover Re /10.6 тэрбум доллар/, Lloyd's /8.4 тэрбум доллар/, Reinsurance Group of America Inc /4.9 тэрбум доллар/ компаниуд тэргүүлж байна.

Даатгалын нөхөн төлбөр 2008 оны эхний хагас хүртэлх санхүүгийн жилд дэлхийн хэмжээнд 2.9 триллион долларт /амьдралын даатгал 1.35 триллион, амьдралын бус даатгал 1.54 триллион доллар/ хүрсэн нь хохирол нөхөлтийн түвшин 72.5 хувьтай байгааг харуулж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн дүнгээрээ АНУ тэргүүлж, дэлхийн зах зээлийн 29.7 хувийг эзэлж байгаа бол Япон /11,12%/, Их Британи /10,87%/, Франц /6,05%/, Герман /4,95%/, Итали /3,21%/, Испани /2,54%/, Канад /2,05%/ зэрэг орнууд удаалж байна.

Дэлхийн даатгалын зах зээлийн хураамжийн орлогын өсөлтөд Азийн орнууд зонхилох байдалтай байдаг ч нөхөн төлбөрийн хэмжээгээрээ тун бага хувийг эзэлж буй нь энэ бүс нутагт даатгалын зах зээл хөгжлийн эхэн үедээ байгаа, хууль, эрх зүйн зохицуулалт нь хөгжингүй орнуудын түвшинд хүрээгүйг илтгэж байна. Нөхөн төлбөрийн өсөлт нь БНХАУ-д

19% , БНСУ-д 15,5%, Японд-5% хувь өссөн бөгөөд энэ нь Азийн даатгалын зах зээлийн 82.4%-ийг эзэлж байна.

2008 оны эхний хагас хүртэлх санхүүгийн жилд нийт нөхөн төлбөрийн дүнгээрээ AXA group /141.2 тэрбум доллар/, Allianz group /118.1 тэрбум доллар/, Assicurazioni General /101.2 тэрбум доллар/, AIG /99 тэрбум доллар/, Berkshire Hathaway /98.9 тэрбум доллар/, Prudential /68.1 доллар/, State Farm Insurance Cos /5 тэрбум доллар/ зэрэг компаниуд тэргүүлж байгаа бол нөхөн төлбөрийн бүтцэд эд хөрөнгийн даатгал 32.56%, амь нас гэнэтийн ослын даатгал 22.6%, арилжааны эрүүл мэндийн даатгал 16.2%, хариуцлагын даатгал 12.3%, санхүүгийн даатгал 15.6%-ийг тус тус эзэлж байна.

Даатгалын салбарын тэргүүлэгч компаниудын нэг болох AIG группийн хувьцааны индекс буурч, санхүүгийн хувьд хүнд байдалд орсон тул түүний хувьцааны 79.9%-ийг АНУ-ын Холбооны нөөцийн газар 85 тэрбум доллараар худалдан авсан нь дэлхийн даатгалын зах зээл дээрх 2008 оны гол үйл явдал боллоо.

Дэлхийн ДНБ-ний өсөлт 2009 онд 0.5 % болж буурах хандлагатай гэж олон улсын банк, санхүүгийн байгууллагууд урьдчилан тооцоолсон нь үнэн байвал даатгалын зах зээлийн хөгжил ч саарах магадлалтай бөгөөд энэ сааралт манай орны даатгалын салбарыг ч тойрон гарахгүй болов уу.

Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд

Даатгалын салбарын өмнө тулгарч буй дараах асуудлуудад онцлох ач холбогдол өгч дунд хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ нь:

-заавал даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн нэвтрүүлэхийн тулд хуульч, хүний эмч, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, орчин тойрноо хордуулж болзошгүй бодистой ажиллагсдад мэргэжлийн хариуцлагын заавал даатгал, амьдралын буюу урт хугацааны даатгал зэрэг даатгалын шинэ шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, тэдгээрийг зохицуулах дүрэм, журам, аргачлалыг боловсруулан мөрдүүлэх;

-Монгол орны даатгалын зах зээлийн өрсөлдөөнийг компанийн тоогоор бус удирдлага, засаглалын дэвшилтэт арга хэлбэрүүдийг нэвтрүүлснээр, санхүүгийн чадавхиар нь төсөөлж, дүрмийн болон нөөц сангийн хэмжээг өсгөх замаар нэгтгэн томруулах, эдгээр сангуудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг санхүүгийн бусад зах зээлд хөрөнгө оруулалт хийж өсгөх боломжийг бүрдүүлэх чиглэлээр Даатгалын тухай хуульд зохих өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэх;

-гадны хөрөнгө оруулалттай даатгалын компани шинээр байгуулах, одоо ажиллаж байгаа компанийг худалдаж авах гэсэн сонирхол нэмэгдэж байгааг харгалзан дэлхийн болон бүс нутгийн туршлагыг судлан хэрэгжүүлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлэх замаар дотоодын даатгалын зах зээлээ хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах;

-Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аливаа байгууллагыг дотоодын даатгалын байгууллагад даатгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгож, зөвшөөрөлгүй даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын даатгалын компаниуд, даатгалын төлөөлөгч, зуучлагчдын үйл ажиллагааг зогсоох;

-даатгалын салбарын талаарх мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангах зорилгоор өнөөгийн шаардлагад нийцсэн программ хангамж бүхий мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, санхүүгийн тайлагналтын олон улсын стандартыг системийн хэмжээнд нэвтрүүлэн мөрдүүлэх;

-дотоодын даатгалын зах зээл дээр давхар даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүлэх зорилтын хүрээнд даавхар даавгалын эрсдэлийн санг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын зорилгоор зарцуулах, үүнд хяналт тавих шаардлага зэрэг эрх зүйн зохицуулалтын журам заавруудыг боловсруулж гаргах зэрэг болно.

3.БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР

Хорооноос бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжиж, тогтвортой байдлыг төлөвшүүлэх, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжин санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, дэд бүтэц, хяналт, зохицуулалтыг сайжруулах зорилгоор 2008 оныг “Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласны дагуу бичил санхүүгийн жилийн хүрээнд хийгдэх ажлын чиглэл, төлөвлөгөөг батлан, энэхүү төлөвлөгөөнд дэвшүүлсэн 6 зорилтыг хэрэгжүүлж ажилласан болно.

А. Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар

Бичил санхүүгийн салбарын бүрэлдэхүүн хэсэг болох Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/, Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/, Валют солих цэг /ВСЦ/-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт зарим талаар зах зээлийн шаардлагад нийцээгүй, нөгөө талаар тодорхойгүй байгаа нь төрийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахын зэрэгцээ иргэд, олон нийтийг бухимдуулж байсан зохисгүй үйлдлүүд давтагдан гарах нөхцлийг бүрдүүлсэн хэвээр байгаа билээ.

Тиймээс, юуны түрүүнд, энэ салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг олон улсын жишиг, стандартад нийцүүлэх замаар дэд бүтэц, хяналт, зохицуулалтыг сайжруулж, улмаар тус салбарын хөгжил, цаашдын тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх явдал тулгамдсан асуудал болж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор ББСБ-дын холбоо, тус салбарт ажиллаж буй мэргэжлийн байгууллагуудаас тавьж буй санал, хүсэлт, гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагуудын жишиг, туршлага зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлээд байна.

ББСБ-дын үйл ажиллагаанд нь мөрдөгдөж буй журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах, ББСБ-дын эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор “ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”, “ББСБ-ын эрхлэх итгэлцлийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”, “ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай

журам”, “Хөрөнгө оруулалт /венчур/-ын үйлчилгээний түр журам” зэрэг нийт 9 журам, заавар, аргачлалыг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдүүлээ.

ХЗХ-дын үйл ажиллагаа өнөөг хүртэл 1998 онд батлагдсан “Хоршооны тухай” хуулиар зохицуулагдсан хэвээр байгаагаас энэ төрлийн байгууллагуудаас нийгэмд үзүүлэх эрсдэл өндөр хэвээр байна гэж хэлж болно. Хэдийгээр СЗХ-оос ХЗХ-дын үйл ажиллагаанд тавих шаардлагыг өндөрсгөж, хяналтыг чангатгаж байгаа ч улс орны түүхэнд нэгэн удаа гарсан бухимдалт байдал давтагдахыг үгүйсгэх аргагүй тул “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” бие даасан хуулийн төслийг боловсруулан, холбогдох яамдын саналыг тусгаад УИХ-д өргөн барьсан ба хуулийн эхний хэлэлцүүлэг хийгдээд байна.

ХЗХ-дын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлж, санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэх зорилгоор “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх болсон.

Валютын арилжаатай холбоотой асуудал Валютын зохицуулалтын тухай хуулиар Монгол банкны бүрэн эрхэд хамаардаг хэдий ч Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хүрээнд тохиролцсоноор СЗХ-нд хариуцуулах болсон тул ВСЦ-дийн үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах зорилгоор "Валют солих цэг ажилуулах журам"-ыг шинэчлэн баталсан. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдан ажиллаж байна.

Тайлант онд бичил санхүүгийн зуучлал, цар хүрээ, хүртээмжийг өргөтгөх, өрсөлдөөнийг дэмжих, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын ашигт ажиллагааны түвшин, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн үйл ажиллагааны эх үүсвэрийг нэмэгдүүлж, дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох арга хэмжээ авсан. Үүнтэй уялдуулан дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүссэн нийт 36 ББСБ-ын дүрмийн санд оруулах өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн болно.

Зах зээлийн зохицуулалтын бодлогын хүрээнд Хороонд хандаж хүсэлт гаргасан 14 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2 ББСБ-д салбар байгуулах зөвшөөрөл олгосноос гадна 8 ББСБ-ын үйл ажиллагааны төрөл нэмэгдүүлэх, 3 ББСБ-ын үйл ажиллагааны зарим төрлүүдийг хүчингүй болгох, 1 ББСБ-ын оноосон нэрээ солиулах, 2 компанийн тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулахтай холбогдсон асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэлээ.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийг зөрчиж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлээгүй, түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй нийт 13 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 4 компанийн 1-3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн байсан тусгай зөвшөөрлийг Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлсэн гэж үзэн сэргээсэн болно.

Хороонд хүсэлтээ гаргасан 45 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, Хоршооны тухай хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлээгүй 17 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Хорооноос

өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаагүй 4 хоршооны 3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн байсан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Улсын бүртгэлд бүртгэлтэй боловч тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй 59 хоршоонд тусгай зөвшөөрөл олгох боломжгүй гэж үзсэний дагуу хяналтад буй хоршоодын бүртгэлээс хасахаар шийдвэрлэснийг Зууны мэдээ сонин, Хорооны веб сайтаар нийтэд зарлаж, тухайн хоршоо болон Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн газарт албан тоотоор мэдэгдсэн болно.

Улсын бүртгэлд бүртгэлтэй боловч Хороонд тусгай зөвшөөрөл авах өргөдөл, баримт бичгийг ирүүлээгүй ХЗХ-дыг УИХ-аас 2007 оны 6 дугаар сард баталсан "Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн дагуу татан буугдах 499 хоршооны Улаанбаатар хотын 227, хөдөө орон нутгийн 61 хоршоо шүүхийн шийдвэрийн дагуу татан буугдлаа.

Улсын бүртгэлд бүртгэлтэй боловч Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, үйл ажиллагаа нь зогсож, санхүүгийн хувьд доройтсон "Төв азийн хөрөнгө оруулалт", "Түмэнтий инвест", "Зиндаа инвест", "Хамтын нөхөрлөл", "Эрдэнийн эргэлт" зэрэг хоршоодын харилцагчдын хохирлыг барагдуулахад онцгой анхаарч сар бүр өглөг, авлагын барагдуулалтын тайланг хүлээн авч, хяналт тавьж ажилласнаас эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэж үзсэн "Түмэнтий инвест" хоршоог УМБГ-аар шалгуулахаар шилжүүллээ.

Хороо Валют солих цэгийн үйл ажиллагааг зохицуулах үүргийг хүлээсэн цагаасаа төрийн хяналтаас хөндийдүү байсан энэ үйлчилгээг Хорооноос авсан зөвшөөрлийн дагуу эрхэлж байхаар цэгцэлж, цаашдын бодлогыг тодорхойлох арга хэмжээ авсан. Үүний дагуу Хорооноос валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг боловсруулж, Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр ажиллаж байсан 52 ВСЦ-т мэдэгдэн, зөвшөөрлөө шинэчлэх авах хугацааг тогтоосон билээ. Оны эцэс гэхэд тавигдсан шаардлагын дагуу Хороонд хандсан 21 хуулийн этгээдийн 25 цэгийн зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосон бөгөөд тогтоосон хугацаанд хүсэлт ирүүлээгүй 39 цэгийн зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Бичил санхүүгийн байгууллагуудын эргэлтийн хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын тусламж дэмжлэгтэйгээр нэмэгдүүлж, бага орлоготой иргэдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг тэлэх бодлогын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны "Тогтвортой амьжиргаа" төслийн бөөний зээлд хамрагдах хүсэлт гаргасан 21 ББСБ, Олон улсын санхүүгийн корпорацийн урт хугацаат хөрөнгө оруулалт хийх төсөлд хамрагдах хүсэлт гаргасан 27 ББСБ, 9 ХЗХ-той холбоотой судалгаа, дүгнэлтийг гаргаж, холбогдох газруудад нь хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд бичил санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон бусад этгээдийн үйл ажиллагаатай холбоотой нийт 2229 албан бичиг, өргөдөл ирсэн бөгөөд хариу шаардсан нийт 468 албан бичгийг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэж, хариу илгээсний дээр ХЗХ-той холбоотой ирүүлсэн 99 өргөдлийг хянаж, хариуг нь хүргүүлсэн болно.

Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролын түвшин ямар байгаагаас ихээхэн хэмжээгээр шалтгаалж байдаг. Манай орны хувьд бичил санхүүгийн байгууллагууд байгуулагдаж эхэлснээс хойш харьцангуй бага хугацаа өнгөрсөн, санхүүгийн хувьд бэхжиж амжаагүйгээс үйлчилгээнийх нь цар хүрээ хумигдмал, нийт санхүүгийн салбарт эзэлж буй хувийн жин нь чамлахаар бага, зохицуулж буй эрх орчин нь сул бүрдсэн зэргээс шалтгаалан хөгжлийн хандлага нь ч бүрэн тодорхойлогдоогүй бөгөөд харилцагчид нь ч ойлголт тааруухан байдалтай байна.

Тиймээс иргэдийн энэ талын санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд Хорооноос тусгайлан анхаарч, боломж, чадамжийн хэрээр төрөл бүрийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Тухайлбал,

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсны дагуу “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэхэд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт уулзалт-ярилцлагыг зохион байгуулж, төрийн холбогдох байгууллагууд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, ББСБ, ХЗХ-дын төлөөлөгчдийг өргөнөөр хамруулсан;
- Улаанбаатар хотноо болсон Бичил санхүүгийн олон улсын байгууллагын 11 дэх удаагийн жилийн уулзалтын бэлтгэл болон зохион байгуулалтын ажилд идэвхтэй оролцож, өөрийн орны бичил санхүүгийн байгууллагуудын төлөөллийг өргөнөөр оролцуулсан;
- Бичил санхүүгийн жил”-ийн ажлын хүрээнд зохиогдсон "Санхүүгийн зах зээлийг сурталчлах" нээлттэй өдөрлөгийн үеэр ББСБ, ХЗХ-дын үйл ажиллагаа болон хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар гарын авлага, унших материал хэвлүүлэн тарааж сурталчилсан;
- "Бичил санхүүгийн хөгжил, хандлага” сэдэвт шилдэг илтгэлийн эрдэм шинжилгээний хурлыг эрдэмтэд, судлаачид, оюутнуудын дунд зохион байгуулж, ирүүлсэн илтгэлүүдийг онол, арга зүйн гарын авлага болгон эмхэтгэж, олон нийтэд тараан түгээсэн;
- Санхүүгийн зах зээл, СЗХ-ноос хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах зорилгоор МУИС-ийн ЭЗДС, Глобал удирдагч дээд сургуулийн НББ-ийн төгсөх ангийн оюутнуудын дунд танин мэдэхүйн “АХА” нэвтрүүлгийг зохион байгуулж, МН-25 телевизээр нэвтрүүлсэн.

Бичил санхүүгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчний мэргэшил, чадавхийг дээшлүүлэхэд түлхүү анхаарч, банк, санхүүгийн чиглэлээр зохион байгуулагдсан гадаад болон дотоодын сургалт, семинар, зөвлөгөөнүүдэд өргөнөөр хамруулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Монголбанкнаас зохион байгуулсан "Гадаад валютын мэргэжилтнүүдийн зөвлөгөөн"-ий зохион байгуулалтын ажил, хэлэлцүүлэгт 11 ББСБ, 2 ВСЦ-ийн төлөөллүүдийг оролцуулсан;
- Монголбанкнаас зохион байгуулсан “Банкны системийн төлбөр тооцоо, нягтлан бодох бүртгэл, мэдээллийн ажилтнуудын зөвлөгөөн”-д Хороо болон зохицуулалтын хүрээний мэргэжлийн байгууллагуудаас нийт 10 төлөөлөл оролцуулсан;
- Улаанбаатар хот, Орхон аймагт байршилтай ХЗХ-дын удирдах бүрэлдэхүүнд “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, "Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны

шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хэрэгжилт, түүнийг ашиглан эрсдэл тооцох аргачлалын талаар сургалт зохион байгуулсан;

- Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU), Тайландын хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос (CULT) Бангкок хотноо зохион байгуулсан “Бизнес хөгжлийн төвөөр дамжуулан хоршоог хөгжүүлэх нь” сэдэвт семинарт Хоршоодын холбооны удирдах зөвлөлийн гишүүдээс оролцуулсан;
- Азийн хадгаламж зээлийн хоршооноос Ханой хотноо зохион байгуулсан “Хоршоодын болон зохицуулалтын байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад хоршоодын төлөөллийг оролцуулсан.

ББСБ, ХЗХ, ВСЦ-дийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор энэ салбарыг зохицуулахын тулд Хорооноос авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээнүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, заавар болон тусгай зөвшөөрөл авсан буюу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон байгууллагын талаар Хорооны вэб-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж байсан.

В.Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар

Хорооноос баталсан хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 44 ББСБ-д тусгай удирдамжийн дагуу шалгалт хийхэд “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон холбогдох бусад эрх зүйн актыг зөрчсөн дараах үйлдлүүд нийтлэг илэрч байлаа. Энэ нь:

- дүрмийн сангийнхаа бүтэц, бүрэлдэхүүнд Хорооны зөвшөөрөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулж, тайлан, тэнцэлд тусгах;
- нягтлан бодох бүртгэлийг холбогдох журмын дагуу хөтлөхгүй байх, тайлан тэнцлийг зөрүүтэй гаргах;
- байгууллагынхаа дүрмийг зөрчиж Дотоод хяналтын алба, Зээлийн хороогоо зохих журмын дагуу ажиллуулахгүй байх;
- зээлийн үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилтийг бүрэн хангадаггүй, зээлийн хувийн хэргийг дутуу бүрдүүлэх зэрэг болно.

Бичил санхүүгийн байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцлийг хянаж, шинжлэн, нэгтгэл хийх замаар зайны хяналтыг тогтмол хэрэгжүүлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахын зэрэгцээ тухай бүр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгч байлаа.

ББСБ-ын санхүүгийн тайлан тэнцэлээр дараах нийтлэг зөрчлүүд илэрч байсан болно. Үүнд:

- зээлийн ангиллыг буруу хийснээс зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг буруу тооцон, улмаар тайланг, тэнцлийг алдаатай гаргах;
- зээлийн төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцааг алдагдуулан зээл олголтыг цөөн этгээдэд төвлөрүүлснээс зээл, хүүгийн төлбөрийг эргүүлэн төлүүлж чадахгүйд хүрч, активын чанар муудах;
- нягтлан бодох бүртгэлийг ННБОУС-тад нийцүүлэн хөтлөхгүй байх;

- гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцааг хангахгүй байх зэрэг зөрчлүүдийг дурдаж болно.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдуулан нийт 3 ББСБ-д 4.9 сая төгрөгийн захиргааны шийтгэвэр ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах үүднээс хугацаатай үүрэг даалгаврыг нийт 9 Улсын байцаагчийн албан шаардлага, тайлангаар өгч, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавихын зэрэгцээ тухай бүр зөвлөгөө өгч ажиллаж байна.

ХЗХ-дын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг чангатган, гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдлийг хуулийн байгууллагатай хамтран таслан зогсоох замаар хадгаламж эзэмшигчдийн хохирсон эрх ашгийг тууштай хамгаалж байж л сая энэ салбарт итгэх иргэдийн алдагдсан итгэлийг сэргээн бататгах учиртай.

ХЗХ-дын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор 23 хоршооны ажлыг газар дээр нь очиж шалган дараах зөрчил, дутагдлууд нийтлэг байгааг илрүүлэв. Энэ нь:

- Хоршооны тухай хуулийг зөрчин гишүүн бус этгээдэд зээл олгож, гишүүн бус этгээдээс хадгаламж авдаг;
- хадгаламж, зээлийн хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй;
- хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгө, гишүүдийн бүртгэлд орсон өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлдэггүй;
- Хяналтын зөвлөл болон Зээлийн хороо нь хуулиар олгосон эрх үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй;
- нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг зохих журмын дагуу хөтөлдөггүй зэрэг болно.

ХЗХ-д санхүүгийн тайлан, тэнцлээ улирал тутам Хороонд ирүүлж хэвшин, тайлангийн шинжилгээгээр гаргасан зөвлөмж, дүгнэлт, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар анхааран ажилладаг болж, Хороо болон ХЗХ-дын хоорондын ажлын уялдаа сайжирч байна.

ХЗХ-дын санхүүгийн тайлан, тэнцэлд дүн шинжилгээ хийж, учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэн, түүнийг залруулан засах үүрэг, даалгаврыг тогтмол өгч байсан. Зайны хяналтаар ББСБ-дын үйл ажиллагаанд илэрч байсан зарим зөрчлүүд ХЗХ-дод ч нэгэн адил илрэхийн дээр чанаргүй зээлийн зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа, нөөц сангийн байвал зохих хэмжээ, үйл ажиллагааны зардлын зохистой түвшин хангагдахгүй байгаа дутагдлууд байсаар байна.

Шалгалтын явцад 3 хоршооны удирдлагын үйл ажиллагааг эрүүгийн хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн, Улсын мөрдөн байцаах газарт шалгуулахаар шилжүүллээ.

Тайлант онд ХЗХ-дын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг тогтмолжуулж, ХЗХ-доос ирүүлсэн улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцлийг хянаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөж, тайлангаар хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан болно.

Шалгалтын дүнг үндэслэн хууль тогтоомж зөрчсөн 7 хоршоонд 3.2 сая төгрөгийн торгууль ногдуулж, 22 хоршоонд улсын байцаагчийн “албан шаардлага”-аар зөрчил арилгах тодорхой үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажилласан болно.

Валют солих цэгүүдийг цэгцэлж, үйл ажиллагааг нь санхүүгийн салбарын аль нэгэн хуульд нийцүүлэн, төрийн хяналтаар зохицуулдаг болгохын тулд, юуны өмнө, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хорооноос авсан байх шаардлага тавьж, Хорооны 2008 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Валют солих цэг ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Чингэлтэй дүүргийн 1, 2 дугаар хороо, Төмөрчний гудамжинд орших 32 валют солих цэгийн ажлыг шалгасан.

Шалгалтын явцад Хорооноос зөвшөөрөл авалгүйгээр ажиллаж байсан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэл өгч, ВСЦ-д журмаар тавигдсан шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг шалган, холбогдох үүрэг, даалгаврыг өгсөн.

Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил, дутагдлаас дурдвал,

- гадаад валютыг арилжаалах ханшийг дэвсгэртийн нэрлэсэн үнийн хэмжээ, хэвлэгдсэн он, гэмтэж зурагдсан зэргээс хамааруулан ялгавартай тогтоох, арилжааны баримтыг хоёр хувь үйлдэж, нэгийг нь үйлчлүүлэгчдэд өгч хэвшээгүй;
- ВСЦ санхүүгийн тайлан гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлж заншаагүй;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээний талаарх мэдээллийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлдэггүй;
- Чингэлтэй дүүргийн Төмөрчний гудамж буюу Найман шаргад байрлаж буй зарим павильоны эзэд өөрийн компанийн нэр дээр валют солих цэг ажиллуулах зөвшөөрөл аваад зөвшөөрөлгүй этгээдэд лангуугаа түрээслүүлэх маягаар ажиллаж буй зэрэг болно.

Өнөөдрийг хүртэл харьцангуй сул хяналтын дор ажиллаж байсан ченжийн захыг нэгдсэн зохицуулалтад оруулж, валют солих үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах нөхцөл бололцоог бүрдүүлснээр харилцагчдын эрх ашгийг хамгаалах явдал чухлаар тавигдаж байгааг шалгалтын дүн харууллаа.

Бичил санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, энэ салбарын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл, факторинг, санхүүгийн түрээсийн үйлчилгээг боловсронгуй болгох арга замыг судалж байна.


Г. Зах зээлийн өнөөгийн байдал

Банк бус санхүүгийн байгууллага

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 132 ББСБ-ын 109 нь Улаанбаатар хотод, 23 нь орон нутагт бүртгэлтэйгээс 11 нь Япон, Их Британи, Ирланд, БНХАУ, БНСУ, Итали, Казахстан зэрэг орнуудын хөрөнгө оруулалттай байна. Тайлант онд ББСБ-дын салбар, нэгжийн тоо 42, хувь нийлүүлэгчдийн тоо 445, ажиллагсдын тоо 657 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 120 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлжээ.

Системийн дүнгээр ББСБ-ууд нийт 18.9 тэрбум төгрөгийн орлого олсны 60.1 хувь буюу 11.6 тэрбум төгрөг нь хүүгийн орлого байсан ба 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

1. Нийт актив




Тайлант онд нийт актив 2007 оныхоос 18.2 хувиар буюу 12.1 тэрбум төгрөгөөр, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 31.4 хувиар буюу 11.1 тэрбум төгрөгөөр тус тус өслөө. Нийт активт орлого авчирдаг активын эзлэх хувь 5.8 хувиар өсч 59.1 хувьд хүрсэн нь зээлийн эрэлт өндөр байгааг харуулж байна.

ББСБ-ууд нийт эх үүсвэрээ гол төлөв өөрийн хөрөнгөөр бүрдүүлдгийн дээр харьцангуй зардал багатай эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлдэг тул активын өгөөж нь банкныхтай харьцуулахад өндөр буюу 6.1 /ROA/ хувьтай байна. Системийн хэмжээнд авч үзвэл ББСБ-дын санхүү, төлбөрийн чадварын гол гол үзүүлэлтүүд хангагдаж байгаа юм.


2.3. Зээлийн багцын чанар

Нийт эх үүсвэр нэмэгдэхийн хэрээр зээлийн өрийн үлдэгдэл өсч, өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өсч, нийт активын 59.1 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл нийт зээлийн багцын 5.7 хувь, нийт активын 3.4 хувийн тус тус эзэлж буйгаас харахад ББСБ-дын зээлийн багцын чанар системийн хэмжээгээр сайн байгаа бөгөөд 2008 онд 2.0 тэрбум төгрөгийн зээлийн болзошгүй эрсдэлийн сан байгуулагдсан байна.



3.3. Зээлийн хүүгийн түвшин



Сүүлийн жилүүдэд ББСБ-ын зээлийн хүү банкныхыг дагаад тогтвортой буурч байсан боловч санхүү, эдийн засгийн хямрал, дотоодын инфляцийн түвшний өсөлттэй уялдаж өмнөх оныхоос 1.3 пунктаар нэмэгдсэн хэдий ч банкны салбарын хүүгийн түвшний өсөлтөөс бага байна. Хүүгийн түвшний өсөлт нь хүүгийн орлогыг нэмэгдүүлдэг ч, зээлийн эрсдэлийг өсгөж, санхүүгийн үзүүлэлтэд муугаар нөлөөлж байдаг тул зээлийн эрсдэлийн санг энэхүү өсөлттэй уялдуулан байгуулж байх нь зүйтэй юм.


4.Өөрийн хөрөнгө, дүрмийн сан



Хорооноос ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэх зорилт тавин дүрмийн сангийнх нь доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор ББСБ-дын өөрийн хөрөнгө тайлант онд өмнөх оныхоос 14.4 хувиар өссөн бөгөөд өөрийн хөрөнгийн 83.6 хувь нь дүрмийн сан буюу хувьцаат капиталаас бүрдэх болсон.

ББСБ-ууд нийт эх үүсвэрийн 70.1 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаагаас өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 8.3 хувьтай байна.


5. Бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр



Үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор банкнаас бага хүүтэй зээл авах, бусад санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах замаар бөөний зээл авах, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зэргээр санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх сонирхол ББСБ-дын хэмжээнд нэмэгдэж байна. Үүний улмаас бусдаас татан төвлөрүүлсэн

хөрөнгийн дүн өмнөх оныхтой харьцуулахад 37.5 хувиар өсч 16.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт эх үүсвэрийн 21.0 хувь болж байна.

6. Ашигт ажиллагаа



Тайлант онд ББСБ-дын нийт орлого 36.9 хувиар нэмэгдсэн байхад нийт зардал 35.1 хувиар өссөн нь татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оныхтой харьцуулахад 44.4 хувь буюу 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Орлогын өсөлт нь зээлийн хүүгийн түвшин, нийт эх үүсвэр, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл, гадаад валютын арилжаа нэмэгдсэн зэргээс шалтгаалсан бол зардлын өсөлтөд гадаад валютын ханшийн хэлбэлзлээс хамаарсан гадаад валютын арилжааны алдагдал, боловсон хүчний болон бусад зардал өссөн байдал нөлөөлжээ.


Хадгаламж, зээлийн хоршоод

Жилийн эцсийн байдлаар Хорооноос хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 209 хоршооны 101 нь Улаанбаатар хотод, 108 нь орон нутагт бүртгэлтэй байгаагаас харахад сахүүгийн бусад төрлийн байгууллагуудтай харьцуулахад ХЗХ-д нь улсын хэмжээнд жигд тархалттай байж, бичил санхүүгийн үйлчилгээг алслагдмал нутгийн хүн амд хүргэхэд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж байгаа юм.

ХЗХ-д 41.7 тэрбум төгрөгийн нийт активтай болсон бөгөөд 12.7 тэрбум төгрөгийн орлого олж, 10.8 тэрбум төгрөгийн зардал гарган ажиллаж, системийн хэмжээгээр 1.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай байсан байна.

ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 6.9 хувиар өсч 27.7 тэрбум төгрөг болсныг 100 хувь зээлийн үйлчилгээнд зориулснаар нийт олгосон зээлийн хэмжээ 32.4 тэрбум төгрөг болж, 1.7 дахин нэмэгдсэн байна. Орлого авчирдаг актив хөрөнгийн дүн 1.8 дахин өсч 35.1 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 84.2 хувийг эзлэх болжээ.

Хорооноос тавьж буй шаардлагын дагуу 5 хувь байвал зохистой гэж үздэг ХЗХ-дын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8.8 хувь байна.



1.ХЗХ-дын активын бүтэц


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 дүгээр сард батлагдсантай холбогдуулж Хоршооны тухай хуульд хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр нэмэлт өөрчлөлт орсон. Хороо Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй байсан 1000-аад ХЗХ-г цэгцэлж тусгай зөвшөөрөлжүүлэх ажлыг хийсний дараа Хорооноос тусгай зөвшөөрөл авсан ХЗХ-дын санхүүгийн тайланг улирал бүр хүлээн авч нэгтгэн, эрсдэлийн удирдлагын нэг хэлбэр болох зайны хяналтыг хэрэгжүүлж, хоршоодын санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцааг хангаж ажиллаж байгаа эсэхэд шинжилгээ хийх ажлыг 2007 оноос эхлэн гүйцэтгэсэн. Тиймээс ХЗХ-дын санхүүгийн байдлын түүх сүүлийн хоёр жилээр нэгтгэгдсэнд зарим харьцуулсан дүгнэлт хийж болох юм.

ХӨРӨНГӨ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	2008 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	34,082,240.23	40,361,741.24
I МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,600,161.35	7,109,734.04
II ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	18,037,539.10	30,653,312.20
III АВЛАГА (ЦЭВРЭЭР)	1,959,909.85	2,076,724.20
IV БУСАД ХӨРӨНГӨ	237,462.53	160,954.75
V ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	247,167.39	361,016.05
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,545,366.05	1,338,597.63
VI ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,318,518.16	1,199,542.65
VII БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	226,847.89	139,054.97
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	35,627,606.28	41,700,338.87

ХЗХ-дын нийт хөрөнгө өмнөх оноос 6.1 тэрбум төгрөг буюу 17.1 хувиар өсч 41.7 тэрбум төгрөгт хүрсэн нь гишүүдээс татан төвлөрүүлсэн хөрөнгө буюу хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ. Хэдийгээр 2.6 хувь байсан хоршоодоос олгож буй зээлийн дундаж хүү 3.6 хувь болж өссөн ч эрсдэл тооцсон цэвэр зээлийн хэмжээ 70 хувиар нэмэгдэж 30.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь Төв банкнаас баримталж буй мөнгөний хатуу бодлогын дагуу арилжааны банкны зээлийн олдоц хомсдосноос бичил санхүүгийн байгууллагын зээлийн хэрэгцээ өндөрссөнийг харуулж байгаа юм.

Нөгөөтэйгүүр, ХЗХ-дын нийт активын 17.0 хувьтай тэнцэхүйц 7.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө зээлд гаралгүй хадгалагдаж байгаагаас төлбөртэй эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байна гэж дүгнэж болох юм.

2.Хоршоодын зээлийн багцын чанар



Тайлангийн хугацанд ХЗХ-доос олгосон нийт зээл өмнөх оныхоос 13.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 32.4 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт зээлд эзлэх чанаргүй /муу, эргэлзээтэй, хэвийн бус/ зээлийн хэмжээ 2007 онд 1.4 тэрбум төгрөг байсан бол 57 хувиар өсч 2.2 тэрбум төгрөг болсонтой уялдаж болзошгүй эрсдэлийн зардал /эрсдэлийн сангийн хэмжээ/өмнөх оныхоос 4.6 дахин нэмэгдэж, 1.7 тэрбум төгрөг болов.

3.Татан төвлөрүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа

Тайлант онд ХЗХ-дын нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 1.9 тэрбум төгрөгөөр буюу 6.9 хувиар нэмэгдэж 27.7 тэрбум төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгө 18.4 хувиар өсч 7.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 47.8 хувиар өсч 3.5 тэрбум төгрөг тус тус болсон нь ХЗХ-дын нэр хүнд өсч, иргэдийн итгэл сэргэх хандлагатай байгааг харуулж байна.

Оны эхэнд 31.6 тэрбум төгрөгт хүрч байсан татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ тогтмол буурч байгаад санхүү, эдийн засгийн хямралын нөлөөлөл үйлчилж, иргэдийн орлого буурахын хэрээр хадгаламж дахь мөнгөн хөрөнгөө буцаан татах хандлага улам бүр ажиглагдаж байгаатай холбоотой байна.

Санхүүгийн боловсролыг дэмжих жилийн ажлын хүрээнд бичил санхүүгийн үйл ажиллагааны мөн чанар, зорилго, цар хүрээ, ирээдүйн хандлагын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах олон талт арга хэмжээ зохион байгуулна.

ГУРАВ. ХОРООНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-ны санхүү, аж ахуйн тасаг нь Монгол Улсын Төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон санхүүгийн холбогдолтой бусад эрхийн актуудыг удирдлага болгон байгууллагынхаа хэвийн, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн төлөө чармайн ажиллалаа.

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулиар батлагдсан СЗХ-ны төсвийг Сангийн яамнаас баталсан хуваарийн дагуу Хорооноос авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг цаг хугацаанд нь санхүүжүүлж, санхүүгийн улмаас аливаа ажил, үйлчилгээг саатуулсан зөрчил гаргалгүйгээр ажлын шуурхай байдлыг хангаж ажилласан юм.

Тайлангийн хугацаанд Үндэсний аудитын газраас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар шат дараалсан арга хэмжээ авсан.

Хорооны санхүүгийн үйл ажиллагааг хуулийн дагуу явуулахын тулд санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, дотоод хяналтын алба, бусад холбогдох хүмүүсээр хянуулж, илэрсэн зөрчил дутагдал бүрийг цаг тухайд нь залруулж, хуулийн хугацаанд нь Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлж байлаа. Аливаа өр, авлагыг шинээр үүсгэхгүй байхын тулд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгал, Татварын болон бусад харилцагч байгууллагуудтай сар бүр тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байв.

Хорооны эд хөрөнгийн тооллогыг хагас жил тутамд хийж, илэрсэн зөрчлийг цаг алдалгүй арилгуулах, эдэлгээний хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон зэрэг шалтгааны улмаас акталж бүртгэлээс хасах үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж, Төрийн өмчийн хороонд шийдвэрлүүлэхээр хүргүүлэх ажлыг хэвшил болголоо.

Улсын санхүүгийн болон төсвийн төлөвлөлтийн арга зүй өөрчлөгдөж бүтээгдэхүүнд суурилсан төсөвлөлт хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан Хорооны дунд хугацааны буюу 2009-2011 оны төсвийн төлөвлөгөөг “Санхүүгийн салбарын зохицуулалт”, “Санхүүгийн хяналт шалгалт” гэсэн 2 хөтөлбөртэй, тус бүр 4 бүтээгдэхүүнтэйгээр боловсруулж, Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн болно.

Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тавилга эд хогшил, бичиг хэргийн материалыг Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн захиалга, зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн нийлүүлж байсны зэрэгцээ эвдэрч, гэмтсэн техник хэрэгслийг засварлуулан хэвийн ажиллагаатай болгох арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авч байсан болно.

Төрийн албанд шатах тослох материал баг зарцуулдаг тээврийн хэрэгсэл ашиглах шийдвэр төр, засгийн эрх бүхий байгууллагуудаас гаргасантай холбогдуулан Хороонд ашиглагдаж байсан Хьюндай-Елентра, Бенз-200 автомашинуудыг Төрийн өмчийн Хорооны

шийдвэрийн дагуу хураалгаж, Хьюндай Террекан автомашиныг Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт балансаас балансад шилжүүлсэн болно. Төрийн өмчийн хорооны мэдэлд шилжүүлсэн Хьюндай-Елентра машиныг зохих журмын дагуу дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан.

Хураалгасан автомашинуудын оронд БНСУ-д үйлдвэрлэсэн, бензинийн зарцуулалт багатай “Соната-6” маркийн 4 машиныг Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоол, УИХ-ын даргын 2008 оны 23 дугаар захирамж, Төрийн өмчийн хорооны 2008 оны 281, 326 дугаар тогтоолын дагуу албан ажлын хэрэгцээнд зориулан албан ёсны борлуулагч болох “Монгол Хьюндай Киа” компаниас худалдан авч, нягтлан бодох бүртгэлд тусгаж, автопаркаа шинэчилснээр тээврийн хэрэгслийн запас сэлбэг, шатах тослох материалын зардлыг хэмнэх болсон.

Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаар тавьсан зорилтоо энэ онд хэрэгжүүлж чадаагүй.

1.Хорооны төсөв

“Монгол Улсын 2008 оны төсвийн тухай” хуулиар Санхүүгийн Зохицуулах Хорооны төсвийг 487.2 сая төгрөг, үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 283.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 28.3 сая төгрөг, бусад урсгал зардал 175.9 сая төгрөг байх бөгөөд үндсэн үйл ажиллагаанаас 255.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос оруулж, 232.2 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан.

Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 4 дүгээр сараас Хорооны төсөв 558.4 сая төгрөг болж цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 368.5 сая, нийгмийн даатгалын шимтгэл 36.8 сая төгрөг, бусад урсгал зардал 153.1 сая төгрөг байхаар Сангийн яамнаас өөрчлөлт оруулсан. Үүний 255.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллаганы орлогоос, 302.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан.

2008 оны 10 дугаар сард хийсэн төсвийн тодотголоор цалингийн сан, унаа, хоолны хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг 39.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсний дагуу Хорооны нийт төсөв 620.6 сая төгрөг болж, үүний дотор улсын төсвөөс санхүүжигдэх хөрөнгийн дүн 302.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн дүн 318.2 сая төгрөг болж өөрчлөгдсөний дагуу төрийн санд төвлөрүүлэн зарцуулсан.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар СЗХ-ны дэргэдэх Санхүүгийн боловсролын нэгдсэн төв"-ийн барилгын ажлын зураг, төсвийн ажлыг хийж, суурийг тавих зориулалтаар 500 сая төгрөг хуваарилсан байсан боловч төсвийн тодотголоор 100.0 сая болгож өөрчилсөн.

СЗХ-ны төсөвт тодотгол хийсэн байдал

Үзүүлэлт	2008 онд батлагдсан	2008 оны 10-р сарын тодотгол	Зөрүү
Зардал			

Үндсэн цалин	282,979.40	380,877.30	97,897.90
Унаа, хоолны хөнгөлөлт		19,263.20	19,263.20
Нийгмийн даатгалын шимтгэл	28,297.90	40,014.00	11,716.10
Бичиг хэргийн зардал	11,000.00	11,000.00	-
Тээвэр, шатахууны зардал	23,487.50	23,487.50	-
Шуудан, холбооны зардал	20,560.00	20,560.00	-
Дотоод албан томилолтын зардал	10,000.00	10,000.00	-
Гадаад албан томилолтын зардал	14,956.60	14,956.60	-
Ном, хэвлэл захиалах авах зардал	2,100.00	2,100.00	-
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,500.00	8,500.00	-
Эд хогшил худалдан авах зардал	20,000.00	20,000.00	-
Төлбөр хураамж, жижиг татвар	10,560.00	10,560.00	-
Мэдээлэл, зар сурталчилгааны зардал	5,000.00	5,000.00	-
Урсгал засварын зардал	7,100.00	7,100.00	-
Гадаадын зочны зардал	800.00	800.00	-
Нэг удаагийн тэтгэмж	16,000.00	17,900.00	1,900.00
Олон улсын гишүүний татвар, хандив	25,905.90	28,495.40	2,589.50
Үйл ажиллагааны нийт зардал	487,247.30	620,614.00	133,366.70
Хөрөнгө оруулалтын зардал	500,000.00	100,000.00	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	487,247.30	620,614.00	133,366.70
Үндсэн үйл ажиллагааны орлого	255,000.00	318,249.60	63,249.60
Төсвөөс санхүүжих	232,247.30	302,364.40	70,117.10
Ажиллагсад бүгд	88	98	
Удирдах ажилтан	16	16	
Гүйцэтгэх ажилтан	72	82	

2. Орлого

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Хороо нь зохицуулалтын хүрээний байгууллагуудаас зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тусгай дансанд төвлөрүүлэн хуримтлуулж, санхүүжилтийнхээ нэг хэлбэр болгон ашигладаг. Хадгаламж банкинд байршиж байсан энэ дансыг Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын 2008 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 5-7а/4157 тоотын дагуу Голомт банкинд шилжүүлэн байршуулсан.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтын хүрээний санхүүгийн салбар тус бүрийн онцлог, үйл ажиллагааных нь хэлбэр, мэргэжлийн оролцогчдын байршил зэргийг харгалзан тогтоосон хэмжээгээр төвлөрүүлдэг ба тайлант онд нийт 550.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хорооны орлогын бас нэг бүрэлдэхүүн хэсэг нь санхүүгийн зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох сургалт, банкинд байршуулсан мөнгөний тогтвортой үлдэгдэлд хүү тооцон авах зэрэг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого байдаг. Энэ төрлийн эх үүсвэрээс 57.5 сая төгрөгийн орлого олсон байна.

Санхүүгийн байгууллагуудад төрийн хяналтыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчилд улсын байцаагч нар 16.6 сая төгрөгийн торгуулийг шийтгэврийн хуудсаар ногдуулсныг улсын төсөвт орлого болгон шилжүүллээ.

3.Зардал

Хороо үндсэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд 744.4 сая төгрөгийн зардал гаргаснаас батлагдсан төсөв 123.7 сая төгрөгөөр хэтэрсний 80 хувийг хөрөнгө оруулалтын зардал буюу албан ажлын хэрэгцээнд зориулан авсан 4 ширхэг суудлын автомашины үнэ болох 99.0 сая төгрөг эзэлж байгаа юм.

Дотоод албан томилолтын зардал 7.5 сая төгрөгөөр, Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, хийх зардал 2.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнийг бичиг хэрэг, шуудан холбоо, төлбөр хураамж зэрэг хэтрээлттэй гарсан зардлуудыг Сангийн яамны Төрийн сангийн зөвшөөрснөөр хооронд нь гүйлгэн санхүүжүүлсэн.

Хороо нь санхүүгийн зах зээлийн сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл, шинжилгээ, судалгаа, онол арга зүйн материалуудыг цаг алдалгүй хүлээн авч, бодлого шийдвэрээ тодорхойлж байх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын үнэт цаасны зах зээлийн мэдээллийн “Блумберг” компанийн 2 ширхэг терминал худалдан авах болсонтой холбогдуулан уг компанийн Гонг-Конг дахь салбар дээр зохиогдсон сургалтад зарим ажилтнаа оролцуулахад 12.6 сая төгрөг зарцуулсан нь гадаад албан томилолтын зардал хэтрэх шалтгаан болсон.

Үнэт цаасны зах зээл сүүлийн жилүүдэд идэвхжиж, шинэ шинэ бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэх болсон нь шийдвэр гаргалтад зарим хүндрэл учруулах болсон. Иймд энэхүү зах зээлийг зохицуулж буй гол хууль болох “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль зах зээлийнхээ хөгжлийн хурдцад нийцэж байгаа эсэхэд мониторинг хийлгэх шаардлага тулгарсан тул Хууль зүйн үндэсний төвтэй гэрээ байгуулж, урьдчилгаа мөнгийг шилжүүлснээс мэдээлэл, сурталчилгааны зардал 3.5 сая төгрөгөөр хэтэрсэн болно.

Хорооны боловсон хүчний урсгалыг багасгах, ажилтнуудын хөдөлмөрлөх урам зоригийг өрнүүлэх, бүтээмжийг сайжруулах зорилгоор Хөдөлмөрийн дотоод журмын 7.7-д “... эх орны түүх, дурсгалт газруудаар 2 жилд нэг удаа аялал зохион байгуулах...”-аар заасны дагуу Архангай аймгийн Хоргын чиглэлд зохион байгуулсан аялалд 7.1 сая төгрөг зарцуулснаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал энэ хэмжээгээр хэтэрсэн юм.

Албан ажлын хэрэгцээнд зориулан 14.2 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 10.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч, хөрөнгийн дүнг нэмэгдүүлснийн дээр ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хүний хурууны хээ мэдрэгч цаг бүртгэлийн программ хангамжийг 1.9 сая төгрөгөөр авсан.

Санхүүгийн боловсролын сургалтын нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг ажлыг санхүүжүүлэхэд 55.6 сая төгрөг, инженер, геологийн судалгааны ажлын санхүүжүүлэхэд 1.2 сая төгрөгийг Хорооны хөрөнгө оруулалтын зардалд тусгагдсан 100.0 сая төгрөгнөөс “Балданс” ХХК, “Жоншт-Уулс” ХХК-д шилжүүлсэн.

2008 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН СУДАЛГАА

№	Зардлын нэр	2008 он		/төгрөгөөр/	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү Дүн	Хувь
1	Цалин хөлс, нэмэгдэл	400,140,500.00	400,140,500.00	-	100.00
2	Нийгмийн даатгалын шимтгэл	40,014,000.00	40,014,000.00	-	100.00
3	Бичиг хэрэг	11,000,000.00	12,864,730.00	1,864,730.00	116.95

4	Тээвэр, шатахуун	23,487,500.00	23,487,500.00	-	100.00
5	Шуудан холбоо	20,560,000.00	24,774,980.00	4,214,980.00	120.50
6	Төлбөр, хураамж, татварууд	10,560,000.00	16,313,181.82	5,753,181.82	154.48
7	Мэдээлэл сурталчилгаа	5,000,000.00	8,515,250.00	3,515,250.00	170.31
10	Дотоод томилолт	10,000,000.00	2,479,761.93	(7,520,238.07)	24.80
11	Ном, хэвлэл	2,100,000.00	2,100,000.00	-	100.00
12	Эд хогшил худалдан авах	20,000,000.00	20,000,000.00	-	100.00
13	Урсгал засвар	7,100,000.00	7,100,000.00	-	100.00
14	Хичээл сургалтын зардал	8,500,000.00	5,620,270.00	(2,879,730.00)	66.12
15	Тэтгэмж, урамшуулал	17,900,000.00	25,072,855.00	7,172,855.00	140.07
16	Гадаад томилолт	14,956,600.00	27,540,277.06	12,583,677.06	184.13
17	Гадаад зочны зардал	800,000.00	800,000.00	-	100.00
18	Гадаадад шилжүүлэг	28,495,400.00	28,495,398.37	(1.63)	100.00
19	Бусад		7,080.62	7,080.62	
20	Урсгал зардлын дүн	620,614,000.00	645,325,784.80	24,711,784.80	103.98
21	Хөрөнгө оруулалтын		99,047,665.00	99,047,665.00	
	Нийт зардал	620,614,000.00	744,373,449.80	123,759,449.80	119.94

4.Өмч, хөрөнгийн хөдөлгөөн

Тайлант хугацаанд Хорооны өмч, хөрөнгө нийтдээ 183.1 сая төгрөгөөр нэмэгдэн, 112.6 сая төгрөгөөр хасагдаж, өмч хөрөнгийн дүн нийтдээ 482.0 төгрөг болсон байна.

“Монгол Хьюндай Киа” компаниас худалдан авсан 4 ширхэг “Соната-6” суудлын автомашины үнийн дүн болох 99.0 сая төгрөг, албан ажлын хэрэгцээнд авсан тоног төхөөрөмж, эд хогшлын үнэ болох 25.4 сая төгрөг, Санхүүгийн боловсролын сургалтын төвийн зураг, төсөв, инженер-геологийн судалгааны ажлын хөлс болох 56.8 сая төгрөгөөр активын дүн өслөө.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 179 дугаар тогтоолоор Хорооны эзэмшлийн 63.7 сая төгрөгийн 2 орон сууцыг эзэмшиж байгаа оршин суугчдад нь хувьчлахаар шийдвэрлэсэн тул Төрийн өмчийн Хорооноос Нийслэлийн орон сууц хувьчлах товчоонд 2008 оны 2/1130 дугаар албан бичгээр олгосон зөвшөөрлийг үндэслэн эдгээр орон сууцнуудын үнийг балансаас хассан болно.

Төрийн өмчийн хорооны шийдвэрээр хураалгасан 3 ширхэг хуучин машины баланс үнэ болох 32.9 сая төгрөг, мөн Хорооны 2008 оны 443 дугаар тогтоолын дагуу актлагдсан компьютер, тоног төхөөрөмж, програм хангамжийн үнэ болох 16.0 сая төгрөгийг бүртгэлээс хассан.

Үндсэн хөрөнгө	Эхний үлдэгдэл	Гүйлгээ		Эцсийн үлдэгдэл
	Дебет	Дебет	Кредит	Дебет
Барилга, байгууламж, орон сууц	116.4		63.7	52.7
Автотээврийн хэрэгсэл	91.1	99.0	32.9	157.2
Машин, тоног төхөөрөмж (компьютер)	147.1	14.2	15.6	145.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	52.3	10.9	0.1	63.1
Бусад үндсэн хөрөнгө	2.1	0.3		2.4

Програм хангамж	2.5	1.9	0.3	4.1
Бусад биет бус хөрөнгө		56.8		56.8
Нийт дүн	411.5	183.1	112.6	482.0

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2008 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2007 оны	2008 оны
ҮЙЛ АЖИЛГААНЫ ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	296,417.1	359,164.4
Бараа үйлчилгээний орлого	637,344.2	622,565.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	933,761.4	981,729.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Ажиллагчидтай холбогдсон зардал	346,362.1	439,716.6
Бараа, үйлчилгээний урсгал зардал	208,892.4	190,276.2
Татаас санхүүжилтийн зардал	67,595.4	53,622.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	622,849.9	683,615.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	310,911.5	298,114.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	2.0	41.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		3,065.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	310,913.5	295,089.8

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

/мянган төгрөг/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2008.01.01.	2008.12.31.
ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	812,920.0	542,648.3
АВЛАГА	674.8	5,293.1
БАРАА МАТЕРИАЛ	8,271.5	21,874.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	303,224.8	331,648.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,125,091.1	901,464.5

ӨР ТӨЛБӨР		
Урьдчилж орсон орлого	513,003.5	64,600.1
Засгийн газрын хувь, оролцоо	612,087.7	836,864.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,125,091.2	901,464.5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2008 он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	981,729.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	(1,080,062.6)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(98,332.8)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,395.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	174,333.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(171,938.9)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(270,271.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	812,920.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	542,648.3

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2008/01/01-ээрх үлдэгдэл	357,743,693.58	0.00	254,344,017.50	612,087,711.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,809,590.46	0.00	0.00	8,809,590.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	77,390,814.56	0.00	1,731,845.04	79,122,659.60
Тайлант үеийн үр дүн			295,089,760.29	295,089,760.29
2008/12/31-ээрх үлдэгдэл	289,162,469.48	0.00	547,701,932.75	836,864,402.23

ХОРОО 2009 ОНД:

“Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд авсан арга хэмжээнүүдийн үр дүнг нэгтгэн үзээд, хэдийгээр төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж чадаагүй ч энэ зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж, өөрчлөлт хийх эхний алхмууд тавигдсан гэж дүгнэн, шинэ он бүрийг байгууллагынхаа стратеги төлөвлөгөөнд тусгагдсан аль нэг зорилтыг хэрэгжүүлэхэд дорвитой ахиц гаргах “нэрэмжит жил” болгон зарлах явдлыг уламжлал болгон үргэлжлүүлэх зорилгоор 2009 оныг “Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх жил” болгон зарлах, тухайн жилд гүйцэтгэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу иргэд, олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар бодитой өөрчлөлт гаргана.

Санхүүгийн салбарыг зохицуулж буй холбогдох бүх хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг зах зээлийн шаардлагын дагуу тодорхойлох, зах зээлийн хөгжилтэй уялдан шинээр шаардагдаж буй хуулиудын төслийг боловсруулах, УИХ-д өргөн барих, батлуулах талаар идэвхтэй ажиллаж, энэ чиглэлээр эрх бүхий байгуулаагуудтай нягт хамтран ажиллана.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд заагдсан ажил, арга хэмжээнүүдийг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгөн, чармайн ажиллана.

Төрийн хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын ёс зүй, хариуцлага, сахилга батыг өндөрсгөх, санхүүгийн салбарт Монголын компанийн засаглалын кодексыг нэвтрүүлэх, тайлагналын механизмыг ил тод болгон сайжруулах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг эрс бууруулахад чиглүүлэн ажиллана.

Хорооны Ажлын албаны бүтцийн илүү оновчтой хэлбэрийг эрэлхийлэн сайжруулах, ажлын зохион байгуулалтыг төрийн албаны шаардлагад нийцүүлэн нягтруулах, гүйцэтгэлийн арга ажиллагааг стандартжуулах замаар чанаржуулах, ажлын байрны нөхцлийг сайжруулах, боловсон хүчний урсгалыг багасгах

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажилласнаар санхүүгийн сахилга батыг чангатган, төсвийн хөрөнгийг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулах явдлыг дахин гаргахгүй, өр, авлага үүсгэхгүйгээр ажиллана.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО